

**БАЯНХОНГОР АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ХЭЛТСИЙН 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2023 оны 11 дүгээр сарын 24

Рашаант

Улсын бүртгэлийн ерөнхий хууль болон хууль тогтоомжид заасан улсын бүртгэлийн байгууллагын бүрэн эрх, чиг үүргийн хүрээнд Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь 2023 онд дэвшүүлсэн зорилт, Засгийн газрын тогтоолоор батлагдсан хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэх, улсын бүртгэлийн үйлчилгээг шуурхай, чанартай хүргэх үндсэн үйл ажиллагааны зэрэгцээ Улсын бүртгэлийн ерөнхий газраас өгсөн зөвлөмж чиглэлийг удирдлага болгон бүртгэлийн ажил үйлчилгээг олон нийтэд сурталчлан таниулах зорилтыг хангахын зэрэгцээ иргэдэд тоон гарыг үсэг олгох, түүний талаар мэдлэг мэдээлэл олгох ажилд онцгойлон анхаарал хандуулан ажиллалаа.

Улсын бүртгэлийн хэлтэс хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд улсын бүртгэлийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, улсын бүртгэгчийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллах, улсын бүртгэлийн эх нотлох баримт бичгийн цаасан болон цахим архив, цахим мэдээллийн санг үүсгэх, хөтлөх, төрөлжүүлэн хадгалах, тэдгээрийн хадгалалт, хамгаалалтын найдвартай байдлыг хангах, улсын бүртгэлийн хөтлөлт, эх нотлох баримтын үнэн зөвийг нягтлан бүрдлийг хангах, илэрсэн зөрчлийг арилгуулах замаар улсын бүртгэлийн үнэн зөв, бодит байдлыг хангах зэрэг үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллав.

Мөн хэлтсийн нийт албан хаагчдад Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, бусад холбогдох хуулийг чанд мөрдөн, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахин, төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх, үйлчилгээний стандартыг баримтлан ажиллахыг үүрэг болгон мэргэжлийн удирдлагаар ханган ажиллалаа.

Хэлтсийн 2023 оны жилийн эцсийн энэхүү тайланд хууль тогтоомж болон үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хэрхэн зохион байгуулсан, байгууллагын стратеги зорилтыг хангах зорилгоор нэгдсэн зохион байгуулалтын арга хэмжээнд хамрагдсан болон хэлтсийн хэмжээнд хийгдсэн ажил, улсын бүртгэгч нарын хийж гүйцэтгэсэн ажил, үйлчилгээг нэгтгэн танилцуулж байна. Үүнд:

- Хөтөлбөр ,төлөвлөгөөний хэрэгжилт;

- Аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ-ын сонгуулийн нөхөн сонгуулийн бэлтгэл ажил, зохион байгуулалт
- Улсын бүртгэлийн (иргэнийн, хуулийн этгээдийн, эд хөрөнгийн) үйлчилгээг түргэн шуурхай, чанартай хүргэх ажлын зохион байгуулалт;
- Бүртгэлийн хяналт
- Санхүү, төсвийн удирдлага, төлөвлөлт болон төсвийн гүйцэтгэл;
- Байгууллагын дотоод ажил, үйл ажиллагааг сурталчлах ажиллагаа;
- Байгууллагын албан хаагчийн сургалт, хөгжил, ёс зүй;
- Орон нутаг дахь хамтын ажиллагаа;
- Идэвхи санаачилга, шинэлэг ажил

### **НЭГ.ХӨТӨЛБӨР, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ**

Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг УБЕГ-аас батлан ирүүлсэн хөтөлбөр түүний хэрэгжилт, тэдгээрийн хүрээнд шаардлагатай тохиолдолд хэлтсээс дэд хөтөлбөр, төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг хангаж ажиллалаа.

Дээрх төлөвлөгөөнүүдийн хэрэгжилтийг хангах ажлыг хариуцан зохион байгуулах ажилтан, албан хаагчийг жил бүр өөрчлөн түүний гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгуулан биелэлтийг хангуулан ажиллаж байна. Улсын бүртгэлийн байгууллагын жендэрийн нэгдсэн бодлогын үйл ажиллагааг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтийг хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч А.Оюунсүвд хариуцан хэрэгжүүлдэг бол хуулийн этгээдийн улсын бүртгэгч Д.Отгонсүрэн Авлигаас урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх дэд төлөвлөгөөний хэрэгжилтийг, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч С.Баярмаа “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” төлөвлөгөөний хэрэгжилт гэх мэт хариуцан хэрэгжилтийг тайлагнан ажиллаж байна. **Хэрэгжилтүүдээс дурдвал:**

Хуулийн этгээд, эд хөрөнгийн бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч **А.Оюунсүвд** Улсын бүртгэлийн байгууллагын жендэрийн нэгдсэн бодлогын үйл ажиллагааг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтийн хүрээнд төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу дараах ажлыг хийж гүйцэтгэлээ.

1. Хэлтсийн даргын 2022 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн 1/920 дугаартай албан бичгээр Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газарт хэлтсийн албан хаагчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах тухай хүсэлтийг хүргүүлж, Эрүүл мэндийн газраас ирүүлсэн хуваарийн дагуу 2023 оны 12 дугаар сарын 22-ны

өдрөөс 30-ны өдрийг хүртэл нийт 22 албан хаагч хамрагдсан бол өнөөдрийн байдлаар нийт 13 албан хаагч нэмэгдэн хамрагдаж нийт хамрагдалт 89,7 хувь байна.

2. 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдөр **“Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аян”-ы** хүрээнд зохион байгуулах **“Гэр бүлийн хүчирхийллийг таслан зогсоход эрчүүдийн оролцоо манлайлал”** хэлэлцүүлэгт хяналтын улсын байцаагч Л.Мэндбаяр, харуул Б.Бат-Оргил нарыг хамруулсан.

3. 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр АЗДТГ-аас Байгууллагын дэргэдэх хороо, зөвлөлийн “Хүйсийн тэнцвэрт байдлын 2022 оны мэдээ”, “Төрийн байгууллагуудын дэргэдэх хороо, зөвлөл, комиссын бүрэлдэхүүний хүйсийн тэнцвэрт байдлын 2022 оны мэдээ”, “Эрэгтэй эмэгтэй хүний наслалтын зөрүүг багасгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийн мэдээ”- г тус тус хүргүүлж ажилласан.

4. Швейцарын хөгжлийн агентлаг, НҮБ-ын хүн амын сангийн дэмжлэгтэйгээр жил бүр зохион байгуулагддаг Жендэрийн үндэсний хорооны “Надаас, танаас, биднээс, эхлэлтэй” уриан дор үндэсний хэмжээний “ХАРИЛЦАН ХҮНДЭТГЭЕ-2023” аянд хэлтсийн хамт олон нэгдэж байгаагаа илэрхийлж зурагт хуудсаар дамжуулан Жендэрийн Үндэсний Хорооны Facebook хуудас дээр байршуулсан.

5. 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдөр хэлтсийн албан хаагчдийн нэгдсэн сургалт дээр нийт албан хаагч нарт 2022 оны “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах нь” сургалтын талаар хийж хэрэгжүүлсэн ажлын тайланг танилцуулж, 2022 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн А/1300 дугаарт Улсын бүртгэлийн байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журмын 13-р зүйлд “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах, ажлын байрны бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, гомдлыг хянан шийдвэрлэх” нь зүйл бие даан нэмж орсныг тайлбарлан, сургалт зохион байгуулсан.

6. АЗДТГ-аас 2023 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 2/118 дугаарт албан бичгээр ирүүлсэн “Жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд хөвгүүд эрэгтэйчүүдийг татан оролцуулах нь” сэдэвт сургалтад хэлтсийн сүлжээний инженер Р.Доржнямбууг хамруулсан.

7. АЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсээс 2023 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр 4/724 дугаарт албан бичгээр ирүүлсэн Хөдөлмөрийн тухай хуулийн зарим заалтын




хэрэгжилтэд үнэлэлт дүгнэлт хийхээр ирүүлсэн маягтын дагуу хариу хугацаанд нь хүргүүлсэн.

8. ХЭҮК-оос зарласан “Ажлын байр-Бэлгийн дарамтгүй орчин” аянд хэлтсийн хамт олон нэгдэж 2023 оны 10 дугаар сарын 11-ний өдөр “Ажлын байрны бэлгийн дарамт хүчирхийлэл” сэдвийн хүрээнд аймаг дахь Хүний эрхийн үндэсний комиссын референт Б.Содонцэцэгээс ээлжит сургалтаа авч, хүний эрхийн талаарх мэдлэг ойлголтоо дээшлүүллээ. Мөн энэ аяны хүрээнд ХЭҮК-ын цахим хуудсанд аянд нэгдэж байгаа мэдээллээ байршуулсан.



9. “Сэтгэцийн эрүүл мэндийн боловсролыг хүн бүрд” аяны хүрээнд Эрүүл мэндийн яамны Сэтгэцийн эрүүл мэндийн төвөөс явуулдаг цуврал онлайн хичээлүүдээс “Стрессийн тухай ойлголт, даван туулах” сэдэвт онлайн хичээлийг хэлтсийн цахим хуудсанд байршуулж албан хаагч нартаа хүргэлээ.

10. Стрессгүй ажлын байр” аяны хүрээнд 2023 оны 10 дугаар сарын 18-ны өдөр аймгийн Цагдаагийн газрын сэтгэл зүйч Д.Хоролгаравыг урьж “Стрессгүй ажлын байр ба хамт олны уур амьсгал” сэдвээр хамт олны дунд сургалт зохион байгууллаа.





**төлөө нэгдье”, “Би ч нэгдэнэ, та ч бас нэгд”, “Үгүй гэж хэлээд өөрчилье-110”** challenge-д хэлтсийн нийт албан хаагчид 100 хувь нэгдэн ажилласан.

5.Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр үйлчилгээг цахимжуулах, шат дамжлага бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх зорилгоор хэлтсийн үйлчилгээний зааланд **E-mongolia**-аар үйлчилгээ авах боломжийг ханган, интернэтэд холбогдсон суурин компьютер, принтер байршуулсан нь иргэдийг цахимаар үйлчилгээ авах боломжийг хангасан талархлыг хүлээсэн ажил болсон.

Мөн Баянхонгор сумын улсын бүртгэгч, Нэг цэгийн үйлчилгээний улсын бүртгэгч, хэлтсийн байранд үйлчилгээ үзүүлж байгаа улсын бүртгэгч тус бүр “Гэрэгэ” пос болон банкны пос машинаар иргэдэд нэг дороос бүрэн үйлчилгээ үзүүлж байна.

7.Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4-д заасан арга хэмжээг заасан хугацаанд цахим хуудаст байршуулж, иргэд олон нийт танилцах боломжоор хангах үүднээс “Шилэн дансны тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-д заасны дагуу [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) сайтад сар бүр тогтмол байршуулан 129 удаагийн мэдээлэл шинэчилж, [www.bayankhongor.burtgel.com](http://www.bayankhongor.burtgel.com) сайтад тогтмол байршуулан 11 удаагийн мэдээлэл шинэчилж ажилласан.

Зарим Албан хаагчдын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд авлигатай тэмцэх соён гэгээрүүлэх ажилд идэвх санаачилгатай оролцох ажил арга хэмжээг тусган хэрэгжилтийг дүгнэхээр ажиллаж байна.

Ийнхүү энд дурдсанчлан бусад хөтөлбөр төлөвлөгөөний хэрэгжилтийг хариуцан ажиллаж буй албан хаагчид бүтэн жилийн турш хэрэгжилтийг хариуцан биелэлтийг гарган холбогдох газарт хүргүүлэн ажиллаж байна.

## **ХОЁР. АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ ДҮҮГИЙН ИТХ-ЫН НӨХӨН**

### **СОНГУУЛИЙН СОНГУУЛИЙН БЭЛТГЭЛ АЖИЛ , ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын нөхөн сонгуулийн бэлтгэл ажлыг бүрэн хангах, сонгуулийн үеэр улсын бүртгэлийн байгууллагын хүлээсэн үүргийг нэр төртэй, хариуцлагатайгаар биелүүлэх, сонгуулийн ажил дуусгаад хуулийн дагуу хийгдэх бүхий л үйл ажиллагааг гүйцэт, гомдол саналгүйгээр дуусгах зэрэг ажлыг амжилттай зохион байгууллаа.

**1. Сонгуулийн бэлтгэл ажлын хүрээнд дараахь ажлыг хугацаанд нь гүйцэтгэж тухай бүрт нь тайлагнаж ажилласан. Үүнд:**

- Баянхонгор аймагт нэг хаяг дээр 10-аас дээш иргэд бүртгэлтэй хаягийн талаар шалгаж, ИУБГ-т илтгэх хуудас хүргүүлсэн.
- Сонгогчийн нэрийн жагсаалтыг шалгаж, ИУБГ-т илтгэх хуудас хүргүүлсэн.

-Сонгогчийн нэрийн жагсаалтад “түр хасав” тэмдэглэгээ хийгдсэн иргэдийн мэдээллийг шалгаж, ИУБГ-т илтгэх хуудас хүргүүлсэн.

-Сонгуулиар ажиллах итгэмжлэгдсэн ажилтнуудыг шалгуулахаар Тагнуулын байгууллагад албан бичиг хүргүүлж, зөвшөөрөл авсан.

-Хэлтсийн дарга итгэмжлэгдсэн ажилтнуудтай гэрээ байгуулан, нууцын баталгаа гаргуулсан.

-ИУБГ-аас ирүүлсэн чиглэлийн дагуу сонгогчийн нэрийн жагсаалтыг 05 дугаар сарын 22-ны өдөр 2 хувь хэвлэж, хэсгийн хороонд болон итгэмжлэгдсэн ажилтанд хүлээлгэн өгч энэ тухай илтгэх хуудсыг ИУБГ-т хүргүүлсэн.

-Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын нөхөн сонгуулийн талаар ИУБГ-аас ирүүлсэн цаг үеийн чиглэл, албан даалгаврыг тухай бүрд нь хийж хэрэгжүүлэн ажиллаж байна.

- Сонгогчийн ирц бүртгэлийн тоног төхөөрөмжийг УБЕГ-аас ирүүлсэн хуваарийн дагуу 2023 оны 06 дугаар сарын 5-ны өдөр татан авч, Тагнуулын байгууллагын хамгаалалтад хүлээлгэж өгсөн болно.

## **2. Сонгогчдын нэрийн жагсаалт хэвлэж, хүлээлгэн өгөх ажлын хүрээнд:**

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 76 дугаар зүйлд заасан журмын дагуу Баянхонгор аймгийн тухайд 9 хэсэг дээр нөхөн сонгууль явагдах болсонтой холбогдуулан Эрх зүйн болон программын сургалтанд хамрагдаж, Сонгогчдын нэрийн жагсаалтыг хэвлэх, хүлээлцсэн акт үйлдэх, лацдах, хүлээлгэн өгөх ажиллагааг 2023 оны 6 дугаар сарын 14-ны 08 цаг 30 минутаас 15 цаг 30 минутын хооронд Баянхонгор аймаг дахь Тагнуулын хэлтсийн 2 мэргэжилтний хяналтан дор амжилттай зохион байгууллаа.

Уг арга хэмжээний хүрээнд зааврын дагуу дараахь ажлыг хийж гүйцэтгэлээ.

Үүнд:

1. Богд сумын 6 хэсэг /3-9-1, 3-9-2, 3-9-3, 3-9-4, 3-9-5, 3-9-6/ , Заг сумын 1 хэсэг /3-16-2/, Баянговь сумын 1 хэсэг /3-4-2/, Баян-овоо сумын 1 хэсэг /3-6-1/-ийн сонгуулийн санал авах байранд улсын бүртгэлийн байгууллагыг төлөөлөн ажиллах “Итгэмжлэгдсэн ажилтан”-уудыг Эрх зүйн болон программын онлайн сургалтанд бүрэн хамруулж, арга зүйн зөвлөгөөг давхар өгч, хууль эрх зүйн мэдээ мэдээллээр хангалаа.
2. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.4-д заасны дагуу “Итгэмжлэгдсэн ажилтан”-аас “**нууцын баталгаа**” гаргуулан авч, хууль тогтоомж хэрэгжүүлэн зөрчил гаргахгүй ажиллахыг үүрэг болгов.

3. “Итгэмжлэгдсэн ажилтан”-уудад тоног төхөөрөмж болон Сонгуулийн программыг актаар хүлээлгэн өгч, зааврын дагуу программтай ажиллах дадлага сургуулилтыг хийлгэж, алдаа гаргахаас урьдчилан сэргийлж бэлтгэл ажлыг сайтар хангахыг зөвлөв.
4. Сонгогчдын нэрийн жагсаалтанд ямар нэгэн өөрчлөлт ороогүй тул лавлагаа хэвлэгдээгүй болно. Харин Сонгогчдын нэрийн жагсаалт болон Сонгогчдын нэрийн жагсаалтад өөрчлөлт оруулсан тухай тайланг хэвлэж, битүүмжлэж, **“Сонгогчдын нэрийн жагсаалт хүлээлгэн өгсөн акт”**-аар хүлээлгэн өглөө.
5. Сонгуулийн хэсэг бүрийн сонгуулийн программыг түгжиж, тоног төхөөрөмжөө лацдан Итгэмжлэгдсэн ажилтануудад “Тоног төхөөрөмж хүлээлцсэн акт”-ын дагуу хүлээлгэн өгөв.

### **3. Сонгуулийн үйл ажиллагааны болон сонгогчийн ирц бүртгэлийн талаар:**

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 76 дугаар зүйлд заасан журмын дагуу Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны нөхөн сонгууль Баянхонгор аймгийн 9 хэсэг дээр, тодруулбал, Богд сумын 3-9-1, 3-9-2, 3-9-3, 3-9-4, 3-9-5, 3-9-6, Баянговь сумын 3-4-2, Баян-овоо сумын 3-6-1, Заг сумын 3-16-2 гэсэн – хэсгүүдэд нөхөн сонгууль явагдлаа.

Улсын бүртгэлийн Ерөнхий газрын даргын тушаалаар батлагдсан “Удирдлагын шуурхай баг”-ийн ажиллах ажлын удирдамжийн дагуу Хэлтсийн даргаар ахлуулсан шуурхай баг 4 хүний бүрэлдэхүүн /Хэлтсийн дарга, хяналтын улсын байцаагч, Иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч, Мэдээлэл технологийн мэргэжилтэн/-тэй ажиллаж, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, сонгогчдын бүртгэлийн үйл ажиллагааг хэвийн, тасралтгүй явуулахад анхаарч, сонгогчдын ирц, бүртгэлийн мэдээг холбогдох маягтын дагуу 11, 16, 20 цагийн байдлаар авч нэгтгэх, танилцуулах ажлыг шуурхай зохион байгууллаа.

Санал авах энэ өдөр Сонгуулийн хууль тогтоомжоор улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлэх чиг үүрэгтэй холбоотой болон сонгогчдын нэрийн жагсаалттай холбоотой гарсан асуудал, мэдээлэл, гомдол байхгүй, мөн сонгогчийн ирц бүртгэлийн техник, тоног төхөөрөмжийн саатал, гэмтэл гараагүй ирц бүртгэлийн үйл ажиллагаа хэвийн амжилттай явагдлаа.



Мөн “Итгэмжлэгдсэн ажилтан”-уудад сонгогчийн ирц бүртгэлийн мэдээгээ цаг тухай бүрт шуурхай өгөх, сонгуулийн хэсгийн санал авах байранд төрийн албан хаагчийн ёс зүйг сахин биелүүлэх, хараат бусаао ажиллах талаар чиглэл өгсөн ба Итгэмжлэгдсэн ажилтантай холбоотой ямар нэгэн гомдол санал гараагүй болно.

Сонгууийн санал авах өдрийн илтгэх хуудсыг хугацаанд нь хүргүүлж, тоног төхөөрөмжийг цагдаагийн болон тагнуулын ажилтны хамгаалалтын дор УБЕГ-т хүлээлгэн өгч ажиллалаа.

## **ГУРАВ.УЛСЫН БҮРТГЭЛИЙН (ИРГЭНИЙ, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН, ЭД ХӨРӨНГИЙН) ҮЙЛЧИЛГЭЭГ ТҮРГЭН ШУУРХАЙ, ЧАНАРТАЙ ХҮРГЭХ АЖЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ;**

Хэлтсийн хамт олон холбогдох хууль тогтоомж, тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм журам, эрх зүйн бусад актууд болон байгууллагын үйлчилгээний стандартыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон иргэдэд түргэн шуурхай чирэгдэлгүй үйлчилж, төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийг чанд баримтлан ажиллалаа.

Иргэний, эд хөрөнгийн, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг чирэгдэлгүй, түргэн шуурхай хүргэх эрх зүйн орчин, орчин үеийн мэдээлэл технологийн шаардлагад нийцсэн цахим үйлчилгээг хүргэх нөхцөл боломж улам бүр төгөлдөршиж байгааг тэмдэглэхэд таатай байна.

### **3.1. ИРГЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:**

Иргэний улсын бүртгэлийн тасгийн хамт олон Улсын бүртгэлийн багц хуулиуд, тэдгээртэй холбоотой бусад хууль, дүрэм, журмуудыг хэрэгжүүлж ажиллахын зэрэгцээ Улсын бүртгэлийн ерөнхий газраас өгсөн үүрэг даалгавар, цаг үеийн ажлыг шуурхай хэрэгжүүлж, гүйцэтгэлийг хангах чиглэлээр 2023 онд хийж хэрэгжүүлсэн, зохион байгуулсан ажлыг тайлагнаж байна.

Тус тасаг нь өөрийн үйл ажиллагааны үндсэн чиг үүргийг орон нутагт хэрэгжүүлэх, Монгол Улсын Засгийн газар, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилт, аймгийн Засаг даргаас Хууль зүй, дотоод хэргийн сайдтай байгуулсан гэрээ, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргатай хэлтсийн даргын байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, Хэлтсийн даргатай байгуулсан тасгийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, Улсын бүртгэлийн багц хууль тогтоомж, тэдгээртэй холбоотой бусад хууль, дүрэм, журам, шийдвэрүүдийн хэрэгжилтийг хангахад анхаарлаа чиглүүлэн ажиллалаа.

Энэ онд хийж хэрэгжүүлсэн үйл ажиллагаа голчлон Цахим шилжилт-Тоон гарын үсэг олголт, тоон гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлэх, иргэний улсын бүртгэлийн мэдээллийн цахим санг цэгцлэх, улсын бүртгэлийн явуулын төхөөрөмжийг ашиглан явуулын үйлчилгээг үзүүлэх, алслагдсан сумын иргэдэд төрийн үйлчилгээг хүргэж төрийн үйлчилгээний хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх, улсын бүртгэлийн анхан шатны нэгжид улсын бүртгэлийн хүрээгүй үйлчилгээг хүргэхэд гол анхаарлаа хандуулсан явдал нь энэ тайлангийн гол онцлог юм.

## **НЭГ. ЦАХИМ ШИЛЖИЛТ-ТООН ГАРЫН ҮСЭГ ОЛГОЛТ БОЛОН ТООН ГАРЫН ҮСГИЙН ХЭРЭГЛЭЭГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР**

### **1.1. Тоон гарын үсэг олголтыг нэмэгдүүлэх арга хэмжээний хүрээнд:**

Монгол Улсын Засгийн газрын “Шинэ сэргэлтийн бодлого” бодлогын баримтын бичгийн Зургаадугаар бүлгийн 6.1. Төрөөс үзүүлэх үйлчилгээг цахимжуулж, төрийн хүнд суртлыг бууруулна."Шинэ сэргэлтийн бодлого"-ыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөрийн 6.1.1."Цахим үндэстэн" болох арга хэмжээг эрчимжүүлж, нийтийн мэдээллийн дэд бүтцийг боловсронгуй болгож, цаасан суурьтай үйл ажиллагааг багасган цахим харилцаанд шилжиж, нийтийн мэдээллийн системээс олж авах, солилцох боломжтой мэдээллийг иргэн, хуулийн этгээдээс шаардахгүй байх нөхцөлийг хангаж, цахимаар үзүүлэх төрийн үйлчилгээний хүртээмж, тоог нэмэгдүүлж, иргэнийг цахим гарын үсгээр хангах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх” гэж төлөвлөсний дагуу Улсын бүртгэлийн Ерөнхий газраас Цахим гарын үсгийн тухай хуулийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд зохион байгуулсан олон талт арга хэмжээг орон нутагт амжилттай хэрэгжүүллээ.

- УБЕГ-аас Тоон гарын үсэг олголтыг идэвхижүүлэх, нэмэгдүүлэх ажлын хүрээнд ХААН банктэй хамтран ажиллах санамж бичиг байгуулж, санамж бичгийн дагуу “Тоон гарын үсэг олголтыг идэвхижүүлэх аян”-г зохион байгуулсан ба уг удирдамжинд заасан 3 сарын хугацаанд тасгийн иргэний улсын бүртгэгч нар нийт **13885** тоон гарын үсэг олголтыг хийсэн ажлын үзүүлэлтээрээ УБЕГ-ын хэмжээнд 5-6 дугаар саруудад тус тус 1-р байр эзэлж, 2400,000 төгрөгийн мөнгөн урамшууллыг хүлээн авсан.

Энэ нь уг удирдамжийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд иргэдийн идэвхи оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн олон талт арга хэмжээг шуурхай, үр дүнтэй, хүртээмжтэйгээр зохион байгуулсан ажлын үр дүн юм. Тодруулбал, Сумуудад болон төрийн байгууллага, сургууль, албан газар, мөн төвлөрсөн томоохон худалдаа үйлчилгээний төвүүдэд “Нээлттэй хаалга” арга хэмжээг зохион байгуулах, улсын бүртгэлийн зөөврийн төхөөрөмжийг ашиглан явуулын үйлчилгээ

үзүүлэх, төрийн байгууллагуудын төрийн үйлчилгээг сурталчлах, үзүүлэх гэх мэт төвлөрсөн арга хэмжээн дээр очиж Тоон гарын үсгийн талаар тайлбар мэдээлэл өгөхийн зэрэгцээ тоон гарын үсэг олголтыг хийх зэрэг арга хэмжээг зохион байгуулсан болно.

- Тоон гарын үсгийн олголтыг нэмэгдүүлэх ажилд тогтмол анхаарч, улсын бүртгэгч байхгүй шалтгаанаар тоон гарын үсэг авч чадахгүй байгаа сум, багийн иргэдэд тоон гарын үсэг олгох, тоон гарын үсэг олголтыг эрчимжүүлэх ажлыг ХААН банкт хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд ээлжит олон ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулж байна. Тодруулбал, Хүрээмарал суманд тоон гарын үсэг олгох ажлыг 10 дугаар сарын 28-29-ний өдрүүдэд улсын бүртгэгч С.Авирмэдийг томилон ажиллуулж, тоон гарын үсэг олгох ажлыг зохион байгуулсан ба тус арга хэмжээний үед 271 иргэнд тоон гарын үсгийг иргэний үнэмлэхний чип болон гар утсанд олголтыг хийж, тоон гарын үсгийг тогтмол хэрэглэж хэвших талаар хүн бүрт зөвлөгөөг өглөө.

- УБЕГ-ын даргын 2023 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн шуурхай хурлаас Тоон гарын үсэг олголтыг тодорхой хувиар нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг ханган ажиллаж, тайланг 2023 оны 12 дугаар сарын 01-ний дотор ирүүлэх үүрэг өгсөн Иргэний улсын бүртгэлийн газрын даргын 2023 оны 11 дүгээр сарын 07-ны 3/10311 дугаарт албан бичгийн дагуу дараахь ажлыг зохион байгууллаа. Үүнд:

1. “Тоон гарын үсэг олгох тухай” Хэлтсийн даргын 2023 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 1/795 дугаарт албан бичгээр сумдын улсын бүртгэгч нарт суманд үйл ажиллагаа явуулдаг албан газар, байгууллагуудын ажилтан, албан хаагчдаас тоон гарын үсэг аваагүй иргэдэд тоон гарын үсгийг бүрэн олгох, тоон гарын үсгээ аваагүй иргэдийн судалгааг баг бүрээр гаргаж тодорхой хувиар хамруулах, ХААН банк, Төрийн банкны эрхлэгч нартай хэлэлцэн тохирч банкаар үйлчилгээ авах иргэн бүрт тоон гарын үсэг олгох, бусад арга хэмжээг өөрийн зүгээс санаачлан зохион байгуулж тайланг 11 дүгээр сарын 27-ны дотор ирүүлэхийг чиглэл болгосон.

2. Аймгийн нэгдсэн эмнэлгийн удирдлагатай ярилцаж тус байгууллагаас тоон гарын үсгээ аваагүй ажилтан, албан хаагчдад тоон гарын үсэг олголт хийх ажлыг 11 дүгээр сарын 09-нд зохион байгуулснаар 34 иргэнд, хөгжлийн бэрхшээлтэй 4 иргэнд гэрээр нь очиж тоон гарын үсэг олгож зорилтод бүлгийн иргэдэд төрийн үйлчилгээг шуурхай хүргэлээ.

3. Төрийн банкны Баянхонгор аймаг дахь салбар банкны захиралд Хэлтсийн даргын 11 дүгээр сарын 08-ны өдрийн 1/796 дугаарт албан бичгийг

хүргүүлж, мөн өөртэй нь тусгайлан албан уулзалт хийж, сумын тооцооны төвүүдэд албан мэдэгдэл хүргүүлж, төрийн банктай Тоон гарын үсэг олголтыг нэмэгдүүлэх арга хэмжээг хамтран зохион байгууллаа. Тус арга хэмжээний хүрээнд Төрийн банкны Баянхонгор аймаг дахь төв салбар банкинд улсын бүртгэгч Б.Ууганбаярыг 11 дүгээр сарын 15-наас 11 дүгээр сарын 23-ны хооронд ажиллуулснаар 178 иргэнд тоон гарын үсэг олгосон байх ба үүнээс 138 иргэний цахим үнэмлэхийн санах ой буюу чипинд, 40 иргэний гар утсанд гар утасны апплкейшнээр дамжуулан олгосон байна.

- Мөн ХААН банкны Баянхонгор аймаг дахь салбар банк, Шаргалжуут тооцооны төв, Баянхонгор сумын Шаргалжуут 8 дугаар багийн Засаг дарга нартай хамтран 11 дүгээр сарын 13-ны өдөр Тоон гарын үсэг олгох, иргэний улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлэх арга хэмжээг зөврийн төхөөрмжийг ашиглан зохион байгууллаа. Тус арга хэмжээний үеэр 102 иргэнд тоон гарын үсэг олгосон байна.

- Аймгийн төвийн улсын болон хувийн хэвшлийн ерөнхий боловсролын бүх сургуулийн 10, 11, 12 дугаар ангийн 16 насанд хүрч иргэний үнэмлэх авсан хүүхдүүдэд сургууль дээр нь очиж тоон гарын үсэг олгосон.


4.Аймгийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан “Хуульчийн Про БОНО өдөр” өөр холбогдох цэгүүдэд очиж Иргэний улсын бүртгэл болон тоон гарын үсгийн талаар мэдээлэл өгч ажилласан.

## **1.2. Тоон гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлэх арга хэмжээний хүрээнд:**

Манай аймгийн хэмжээнд өнөөдрийн байдлаар 53464 тоон гарын үсэг олгогдож, тоон гарын үсэг олголт 90,3 хувьтай байна.

**А.Улсын бүртгэгч нараас олгосон тоон гарын үсгийн олголтын тоо:**  
(2022.05 сараас 2023.11 сар хүртэлх хугацаанд)

### Тоон гарын үсэг олголтын тоо



Б. 2022 оны 05 сарын 02-ноос 2023 оны 11 сарын 20-ны хооронд олгосон Тоон гарын үсгийн тоо - Аймгийн хэмжээнд




1. Тоон гарын үсэг олголт ийнхүү өндөр хувьтай байгаа боловч аймгийн хэмжээнд 16-аас дээш насны **58553** иргэний хэдэн хувь нь тоон гарын үсгээ авсан бодит тоог гаргаж, цаашдын хийж хэрэгжүүлэх ажлыг оновчтой төлөвлөх, нөгөөтэйгүүр эрх бүхий төрийн байгууллагыг бодит тоон мэдээллээр хангах зорилгоор УБЕГ-ын Мэдээлэл технологийн газарт Хэлтсийн даргын 2023 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 1/785 дугаарт албан бичгээр хандан Тоон гарын үсэг олгогдсон Баянхонгор аймгийн харъяат иргэдийн жагсаалтыг гаргуулан авч, нэгтгэн дүгнэлт хийлээ.

Мэдээлэл технологийн газраас ирүүлсэн жагсаалтад буюу Тоон гарын үсэг олголтын “Gsign.mn” системд бүртгэгдсэн 1 иргэнд хэдэн удаа **“олгогдсон”**, хэдэн иргэнд **“хүсэлт үүссэн”**, хэдэн иргэнд **“үүсгэгдсэн”** гэх төлөвтэй бүртгэгдсэн байгааг мэдэж авахын зэрэгцээ сум сумаар нь тодорхой тоо гаргах боломжтой болсон юм. Нөгөөтэйгүүр 1 иргэнд хэд хэдэн удаа буюу 2-оос дээш удаа **“үүсгэгдсэн”**, **“хүсэлт үүссэн”** гэх төлөвүүд нь сүлжээ, программын байдлаас, өөрөөр хэлбэл, сүлжээ удаан байх, сүлжээ тасрах, программ удаан унших гэх мэт шалтгааны улмаас хэд хэдэн удаа бүртгэгдэх, хэд хэдэн удаа **“үүсгэгдсэн”**, **“хүсэлт үүссэн”** гэх төлөвүүд үүсдэг юм байна гэсэн **дүгнэлт хийж байна.**

Баянхонгор сумын харъяат 16-аас дээш насны **58553** иргэн байхаас **11612** иргэнд Тоон гарын үсэг олгогдсон байна.

**Тоон гарын үсэг олголтын тоог сум сумаар болон хувь хэмжээгээр нь харуулбал:** (Хамрах хугацаа: 2022.05.02-ноос 2023.11.20 хүртэл)



№	Сумын нэр	Тоон гарын үсэг авсан иргэдийн тоо	Хүн амын 16-аас дээш насны иргэдийн тоо	Хувь
1	Баянхонгор	3451	21167	16,3
2	Баацагаан	565	2164	26,1
3	Баянбулаг	261	1178	22,4
4	Баянговь	391	1990	19,6
5	Баянлиг	456	2539	17,9
6	Баян-овоо	349	1644	21,2
7	Баянцагаан	418	1926	21,7
8	Баян-өндөр	196	1727	11,3
9	Богд	588	2003	29,3
10	Бөмбөгөр	582	2096	27,7
11	Бууцагаан	409	2418	16,9
12	Галуут	512	2816	18,1
13	Гурванбулаг	357	1511	23,6
14	Заг	386	1390	27,7
15	Жаргалант	571	2035	28,0
16	Жинст	355	1394	25,4
17	Хүрээмарал	275	1259	21,8
18	Өлзийт	719	2619	27,4
19	Шинэжинст	306	1691	18,0
20	Эрдэнэцогт	465	2986	64,2
21	<b>Нийт дүн</b>	<b>11612</b>	<b>58553</b>	<b>19,83</b>

2. Харин тоон гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлэх, тоон гарын үсгээ хэрэглэж хэвшүүлэхэд чиглэсэн мэдээлэл өгөх, гар утасны апплейкшнээ ашиглан хэрхэн хэрэглэх, улсын бүртгэлийн хичнээн төрлийн үйлчилгээг **E-Mongolia, E-Business** цахим платформаас тоон гарын үсэг ашиглан төрийн цахим үйлчилгээ авах зэрэг арга зүйн сургалтыг аймгийн Цахим үйлчилгээний хэлтэстэй хамтран **“Төрөөс үзүүлж байгаа цахим үйлчилгээтэй холбоотой асуудлаар иргэн, хуулийн этгээдэд зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах хүрээнд төрийн цахим үйлчилгээг олон нийтэд сурталчлан таниулах уулзалт сургалтын удирдамж”**-ийг аймгийн ЗДТГ-ын даргаар 2023 оны 10 дугаар сарын 09-ны өдөр батлуулж,

удирдамжаар батлагдсан хуваарийн дагуу 20 төрийн байгууллагын 200 гаруй ажилтан, албан хаагчид сургалтанд хамрагдлаа.

Тус уулзалт, сургалтын зорилго нь орон нутгийн хэмжээнд төрийн үйлчилгээг хурдан шуурхай хүргэх ажлыг зохион байгуулах, төрөөс үзүүлж буй цахим үйлчилгээг олон нийтэд сурталчлан таниулах, тоон гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлсэнээр төрийн цахим үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, иргэдийн цахим ур чадварын дээшлүүлэхэд чиглэгдсэн. Харин тус сургалтын үр дүнд иргэдийн цахим ур чадвар дээшилж, мэдээллийн аюулгүй байдлаа хамгаалах арга барилд суралцсан байх, Тоон гарын үсгийн хэрэглээ нэмэгдсэн байна гэж үзэж байна.

Уг зорилгод сургалтыг цаашид үргэлжлүүлэн зохион байгуулж, сургуулийн ахлах ангийн сурагчдыг 2024 онд “**Цахим шилжилт-бүртгэлийн цахим үйлчилгээний хөтөч**”-өөр бэлтгэхээр төлөвлөсөн болно.

## **ХОЁР. ЦАХИМ ШИЛЖИЛТ- ИРГЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЦАХИМ САНГ ЦЭГЦЛЭХ АЖЛЫН ЧИГЛЭЛЭЭР**

**2.1. Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн цахим санг цэгцлэх ажлын хүрээнд:**

**3.** Иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн санг цэгцлэх ажлын хүрээнд Иргэний улсын бүртгэлийн газраас жагсаалтаар ирүүлсэн “**нөхөн шивэлт**” төлөвтэй 29, насанд хүрээгүй иргэдийн төрсний бүртгэл ороогүй, алдаатай төлөвтэй 12 иргэний мэдээллийг нэг бүрчлэн тулган шалгаад Хэлтсийн даргын албан бичгээр ИУБГ-т танилцуулсан.

Дээрх дурьдагдсан зөрчлийг арилгах арга хэмжээний хүрээнд архивын цаасан суурьт баримтыг архиваас татан цахим сантай нэг бүрчлэн тулган шалгаж, зөрчилгүй 4 иргэний мэдээллийг Хяналтын улсын ахлах байцаагчийн 2023 оны 4865 дугаарт дүгнэлтийг үндэслэн цахим санд нэмэлт өөрчлөлтийн бүртгэлээр засаж, бүртгэлийг зөв болгов.

Харин үлдсэн 25 иргэний бүртгэлийн мэдээллийг залруулах, зөв болгохоор Хяналтын улсын байцаагчид танилцуулан 2023 оны 6338, 6337 дугаарт дүгнэлтүүдийг гаргуулан, уг дүгнэлтийг үндэслэн төрсний бүртгэлийг нөхөн бүртгэх бүртгэлээр цахим санд оруулж, “нөхөн шивэлт” төлөвтэй “эцэг тогтоолтын бүртгэл”, “үрчилсний бүртгэл” “Ургийн овог, овог, өөрийн нэр өөрчлөлтийн бүртгэл” зэрэг бүртгэлүүдийн төлөвийг “баталгаажуулсан” төлөвт шилжүүлэн бүртгүүлэхээр Иргэний улсын бүртгэлийн газарт [ch.battsetseg@burtgel.gov.mn](mailto:ch.battsetseg@burtgel.gov.mn) хаягаар 2023 оны 11 дүгээр сарын 20-нд танилцуулаад байна.



4. УБЕГ-ын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3 дугаар зорилтын “**3.3.Улсын бүртгэлийн цахим санг үнэлж, дүгнэлт гарган мэдээллийн санг цэгцлэх**”, мөн иргэний улсын бүртгэлийн “**Баталгаажуулалтын бүртгэл**” хийх явцад цахим санд байгаа алдаа зөрчлийг арилгах зорилгоор сумдын улсын бүртгэгч нарт “**Хугацаатай үүрэг даалгавар өгөх тухай**” Хэлтсийн даргын 2023 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 1/729 дугаарт албан бичгээр цахим санд **нэгдүгээрт**; 2007 оны 10 сарын 01-нээс 2009 онд төрсөн Биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлд анх удаа бүртгүүлэх иргэдийн иргэний улсын бүртгэлийн мэдээллийг цахим сан болон Мэдээлэл лавлах системтэй тулган шалгаж, мэдээлэл нь алдаатай, зөрүүтэй, дутуу орсон, огт ороогүй зэрэг алдаа зөрчлийг ирүүлж, мэдээллийг ирүүлэх, **хоёрдугаарт**; Иргэний улсын бүртгэл мэдээллийн цахим санд 2019 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс 2023 оны 10 дугаар сарын 01-ны өдрийг хүртэлх хугацаанд бүртгэгдсэн ИУБ-31 ба ИУБ-21-ны бүртгэлийн мэдээллийг шалгаж, “**хүчинтэй**”, “**бүртгэсэн**”, “**шалгасан**”, “**шалгаж байна**”, “**алдаатай**”, “**нөхөн шивэлт**” гэсэн төлөвтэй бүртгэлүүдийг жагсаалтаар ирүүлэх хугацаатай үүрэг даалгавар өгч, заасан хугацаандаа тайланг нь аваад, тус өгөгдлийг боловсруулан, дараагийн хугацаатай даалгаврыг өгч, биелэлтийг энэ оны 12 сардаа багтаан хийж дуусгахаар төлөвлөсөн болно. **Үүнд:**

**1. 2019 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс 2023 оны 10 дугаар сарын 01-ний өдрийг хүртлэх хугацаанд бүртгэсэн нийт ИУБ-21-ын бүртгэл нийт 19377 бүртгэгдсэнээс өмнөх бүртгэл “хүчинтэй” төлөвтэй 2809 бүртгэл байсныг Бүртгэлийн хяналтын газрын Хяналтын улсын ахлах байцаагчийн 2022 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 1497 дугаар дүгнэлтээр “хүчингүй” төлөвт шилжүүлэн бүртгэж дуусгахыг үүрэг болгож, 11 дүгээр сарын 15-ны дотор бүртгэлийг залруулж дуусгалаа.**

2.2007 оны 10 сарын 01-нээс 2009 онд төрсөн Биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлд анх удаа бүртгүүлэх иргэдийн бүртгэл мэдээллийг шалгуулж дууссан ба эдгээр оны иргэдийн ХААТР-11, ХААТР-13, ХААТР-14 маягтыг цахимжуулах ажлыг эхлүүлсэн. Хуваарийн дагуу өнөөдөр Баянбулаг, Заг сумууд цахимжуулж дууссан байна. Харин бусад сумууд 12 сардаа багтаан цахимжуулж дуусгахаар хуваарь гаргасан болно.

Мөн энэ ажлын дүнд 2007-2009 онд төрсөн иргэдийн мэдээлэл нь зөрүүтэй байгаа иргэдийн жагсаалтыг гаргасан ба энэ ондоо багтаан нэмэлт өөрчлөлтийг хийж бүртгэлийн зөрчлийг арилгах арга хэмжээг авах болно.

3. Цахим санг цэгцлэх зорилтод арга хэмжээний хүрээнд “**Хугацаатай үүрэг даалгавар өгөх тухай**” Хэлтсийн даргын 2023 оны 10 дугаар сарын 09-ний

өдрийн 1/738 дугаарт албан бичгээр сумдын улсын бүртгэгч нараас “**нас тодорхойгүй буюу иргэний шинэчилсэн бүртгэлд хамрагдаагүй иргэд**”-ийн (нас тогтоолгох шаардлагатай) судалгаа, “**нас барсан боловч иргэний улсын бүртгэлийн “нас барсан” бүртгэлд хамрагдаагүй иргэд**”-ийн судалгаа, “**16 нас хүрсэн боловч шинэчилсэн бүртгэлд хамрагдаагүй, 25, 45 насны сунгалтаа хуулийн хугацаандаа багтаан хийлгүүлээгүй иргэд**”-ийн судалгааг тус тус гаргуулсан.

Харин уг судалгааны дүнд дараах ажлууд хийгдэж, бүртгэлийн тодорхой зөрчлүүд арилж байна. Үүнд:

1. Нас барсан боловч нас барсны бүртгэлд хамрагдаагүй 12 иргэн байснаас бүртгэлд хамруулсан нь 5, бүртгэлд хамруулж амжаагүй 7 байна. Нас барсан бүртгэлд бүртгүүлж чадаагүй шалтгааныг тодруулахад Эмнэлгийн байгууллагаас бичгээ авч чадаагүй, нас барсан бичгийг авахад эмнэлгийн байгууллагаас гаргаж өгөхгүй байна гэсэн тайлбарыг иргэд хэлж байв.

2. Бичиг баримтгүй болон тодорхойгүй 10 иргэний мэдээлэл гарч ирсэн. Эдгээр иргэдийн мэдээллийг тодруулахаар Улсын бүртгэлийн нэгдсэн архивт хүргүүлэхээр бэлдэж байгаа болно .

3. Хоёр регистрийн дугаартай 2 иргэний мэдээлэл гарч ирсэн ба эдгээр иргэдийн мэдээллийг шалган хяналтын улсын байцаагчид шилжүүлэхээр архивын баримтыг судлаж байна.

4. 16 нас хүрсэн боловч биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлд бүртгүүлээгүй, 25, 45 насны сунгалтаа хуулийн хугацаандаа багтаан бүртгэлээ хийлгүүлээгүй иргэдийн судалгааг гаргуулсан ба уг судалгааны дүнд 16 нас хүрсэн боловч биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлд бүртгүүлээгүй -62, харин 25 насны сунгалтаа хийлгүүлээгүй-135, 45 насны сунгалтаа хийлгүүлээгүй- 93 байна. Эдгээр иргэдийн бүртгэлийг 12 сардаа багтаан бүртгэлд бүрэн хамруулах үүргийг улсын бүртгэгч өгсөн болно.

4. Улсын бүртгэгч нар төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө цахим сан цэгцлэх, бүртгэлийн зөрчил арилгахтай холбоотойгоор тодорхой төрлийн бүртгэлийг цахим санд шүүж тайлагнаж байгаа идэвхитэй санаачлагатай улсын бүртгэгч нар байгааг тайланд онцгойлон дурьдах нь зүйтэй болов уу. Тодруулбал, Богд сумын улсын бүртгэгч Д.Мягмар 1983-2000 оны гэрлэлтийн бүртгэлийг цахим санд шалгаж, гэрлэлтийн бүртгэл нь санд ороогүй 141 иргэний мэдээллийг жагсаалтаар ирүүлсэн, Баянхонгор сумын улсын бүртгэгч Г.Бадамханд 2005-2007 онд төрсөн 16 нас хүрээгүй иргэдийн төрсний бүртгэлийг

цахим санд шалгаж зөрчилтэй иргэдийн мэдээллийг жагсаалтаар ирүүлж зөрлчийг арилгуулах арга хэмжээг авч шийдвэрлүүлсэн байна.

## **ГУРАВ. УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЯВУУЛЫН ҮЙЛЧИЛГЭЭГ ҮЗҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР**

### **3.1. Алслагдсан сум, багийн иргэдэд улсын бүртгэлийн үйлчилгээг хүргэх ажлын хүрээнд:**

1. Анхан шатны нэгжид болон зорилтод бүлэгт улсын бүртгэлийн явуулын төхөөрөмжийг ашиглан улсын бүртгэлийн үйлчилгээг газар дээр нь хүргэж, үйлчилгээний хүртээмжтэй, шуурхай байдлыг нэмэгдүүлэх зорилтыг хангах арга хэмжээний хүрээнд **“Улсын бүртгэлийн явуулын үйлчилгээ үзүүлэх өдөрлөг”**-ийг Бууцагаан, Баянбулаг, Хүрээмарал суманд 2023 оны 10 дугаар сарын 26-29-ны өдрүүдэд зохион байгууллаа.

Тус өдөрлөгөөр Бууцагаан, Баянбулаг суманд иргэний улсын бүртгэлийн чиглэлээр улсын бүртгэгч З.Дуламсүрэн ажиллаж, тоон гарын үсэг олголтын бүртгэл 34, гадаад паспортын бүртгэл 34, иргэний улсын бүртгэлийн лавлагаа 3 иргэнд олгосон, тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч П.Бүжинлхам Бууцагаан сумын Залуу малчдын зөвлөгөөнд оролцож буй 320 гаруй малчдад болон сургуулийн 30-аад багш, ажилтан нарт Улсын бүртгэлийн цахим үйлчилгээг сурталчлан таниулахад болон Тоон гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлэхэд чиглэсэн мэдээллийг хүргэж, арга зүйн сургалтыг хийлээ.

2. Хүрээмарал суманд ХААН банкны Баянхонгор аймаг дахь салбартай хамтран тоон гарын үсэг олголтыг эрчимжүүлэх ажлыг 10 дугаар сарын 28-29-ны өдрүүдэд зохион байгуулсан ба улсын бүртгэгч С.Авирмэд тус арга хэмжээний үед **271 иргэнд тоон гарын үсгийг** иргэний үнэмлэхний чип болон гар утсанд олголтыг хийж, тоон гарын үсгийг тогтмол хэрэглэж хэвших талаар хүн бүрт зөвлөгөөг өглөө.

Хүрээмарал суманд 2022 оны 02 сараас хойш өнөөг хүртэл улсын бүртгэгч томилогдоогүй, 2022 оны 05 сарын 01-нээс 2023 оны 01 сар хүртлэх хугацаанд **174 тоон** гарын үсэг олгосон байсан болно.

3. 2023 оны 10 сарын 15-ны өдөр Аймгийн ЗДТГ, ИТХ, аймгийн ГХУС33-аас хамтран Бөмбөгөр суманд зохион байгуулсан төрийн байгууллагын **“НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨРЛӨГ”** арга хэмжээнд Хэлтсээрээ хамтран оролцож улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлсэн ба тус арга хэмжээний үед иргэний улсын бүртгэлийн үйлчилгээний гадаад паспортын үйлчилгээг 2 иргэнд үзүүлж, харин 14 иргэнд тоон гарын үсэг олголт хийсэн байна.

4. Баянцагаан сумын иргэдийн захиалгаар 2023 оны 10 сарын 28, 29-ны буюу амралтын өдрүүдэд газар дээр нь очин гадаад паспортын үйлчилгээг 92

иргэнд улсын бүртгэгч Р.Насанжаргал үзүүлсэн ба үндэсний энгийн гадаад паспортын үйлчилгээ авсан иргэдээс сургуулийн багш ажилчид 44, тэмцээнд оролцох 20 сурагчид, 28 нь тус сумын иргэд байна.

### **3.2. Зорилтод бүлгийн иргэдэд улсын бүртгэлийн явуулын үйлчилгээ үзүүлэх ажлын хүрээнд:**

- Баянхонгор сумын ЗДТГ-аас Баянхонгор сумын төвийн 9 багийн зорилтод бүлгийн иргэдийн судалгааг ирүүлэх тухай Хэлтсийн даргын 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 1/759 дугаарт албан бичгийг хүргүүлэн, холбогдох судалгааг гаргуулан авсан ба уг судалгаагаар ирүүлсэн 34 иргэдээс утас нь холбогдохгүй, гэртээ байхгүй, хотод эмчилгээнд яваа гэх мэт шалтгаанаар улсын бүртгэлийн үйлчилгээг авч чадаагүй ба харин гэрт хэвтэрт байдаг, харвалт өгсөн, хараагүй болсон гэх 4 иргэнд иргэний улсын бүртгэлийн Иргэний үнэмлэхний дахин олголтын бүртгэлийн үйлчилгээг үзүүлж, тоон гарын үсэг олголтыг хийлээ.

- Аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын урьдчилан хорих ангид хоригдож байсан 3 иргэнд буюу 16 нас хүрээд биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлд анх удаа бүртгүүлж байгаа 1, 25 насны сунгалтын бүртгэл хийлгүүлсэн 2 иргэнд улсын бүртгэлийн үйлчилгээг зөөврийн төхөөрөмжийн тусламжтайгаар хүргэлээ.

- Мөн эмнэлэгт хүнд өвчтэй хэвтэрт байгаа 1 иргэний хүсэлтийн дагуу эмнэлэгт очиж, гэрлэлтийн бүртгэл-1, эцэг тогтоолтын- 4 бүртгэлийг хийж, иргэний эрхийг ханган, улсын бүртгэлийн шуурхай үйлчилгээг үзүүллээ.

**3.3.** Аймаг орон нутгаас зохион байгуулж байгаа нэгдсэн, төвлөрсөн арга хэмжээ бүрийг алгасалгүй, тогтмол оролцож иргэн бүрт төрийн үйлчилгээг хүргэх, иргэн бүрт улсын бүртгэлийн үйлчилгээг танилцуулах арга хэмжээг зохион байгууллаа. Үүнд:

1. Аймгийн 1000 малчны зөвлөгөөний үеэр хөдөө сумаас ирсэн малчдад төрийн үйлчилгээг шуурхай хүргэх, төрийн үйлчилгээг таниулан сурталчлах арга хэмжээнд оролцож, улсын бүртгэлийн байгууллагын цахим үйлчилгээг сурталчлан таниулах, зөвлөгөө мэдээллийн үйлчилгээ үзүүлэхийн зэрэгцээ тоон гарын үсэг олголтын үйлчилгээ үзүүлж, 26 иргэнд тоон гарын үсэг олгосон байна.

2. Жаргалант, Баянговь сумуудад бүсчилэн зохион байгуулагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн группын хуралд сүлжээний зөөврийн төхөөрөмжөөрөө газар дээр нь очиж, тоон гарын үсэг олголтыг хийсэн.

3. Аймгийн Нэгдсэн эмнэлэгээс зохион байгуулдаг сар бүрийн группын хурлын үеэр зөөврийн төхөөрөмжийг ашиглан 3 удаагийн тоон гарын үсэг олголт

хийх арга хэмжээг зохион байгуулсан ба уг арга хэмжээний үеэр 200 гаруй иргэдэд тоон гарын үсэг олгож, 24 иргэнд иргэний улсын бүртгэлийн лавлагааны үйлчилгээг үзүүлж, эмнэлэгийн байгууллагатай хамтран ажиллаа.

Цаашид алслагдсан болон улсын бүртгэгч байхгүй сум, багийн иргэдэд улсын бүртгэлийн явуулын үйлчилгээг үзүүлж, төрийн үйлчилгээг шат дамжлага багатай шуурхай, иргэдэд ойр төрийн үйлчилгээг үзүүлэх арга хэмжээг хүртээмжтэй байдлаар үзүүлэх шат дараалсан арга хэмжээг 2024 онд үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.

Мөн энэхүү зорилтот арга хэмжээг хэрэгжүүлэхэд зөөврийн төхөөрөмж маш чухал үүрэг гүйцэтгэж байгаа тул 2024 онд зөөврийн төхөөрөмж нэмж авах хүсэлтийг УБЕГ-т хүргүүлэх болно.

#### **ДӨРӨВ.ЕРӨНХИЙ ГАЗРААС БОЛОН УДИРДЛАГААС ӨГСӨН ЧИГЛЭЛ, ЗӨВЛӨМЖ, ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТИЙН ТАЛААР:**

**4.1 Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2022 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 4/134 тоот “Иргэний улсын бүртгэлийн эх нотлох баримт бичгийг цахимжуулах тухай” албан бичгийн биелэлтийн талаар:**

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2022 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 4/134 тоот “Иргэний улсын бүртгэлийн эх нотлох баримт бичгийг цахимжуулах тухай” албан бичгийн дагуу **2023 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар** өссөн дүнгээр төрсний бүртгэл-**6160**, гэрлэсний бүртгэл-**1720**, гэрлэлт дуусгавар болсон бүртгэл-**324**, үрчилсэний бүртгэл-**212**, эцэг эх тогтоосны бүртгэл-**294**, овог, эцэг эх, өөрийн нэр өөрчилсөний бүртгэл-**339**, нас барсаны бүртгэл-**1459**, иргэний үнэмлэхний бүртгэл-**4771**, регистрийн дугаар өөрчлөлтийн бүртгэл-**3**, шилжилт хөдөлгөөн-**5076**, үндэсний энгийн гадаад паспорт -**4265** нийт **24623** хуудас холбогдох эх нотлох баримтуудыг цахимжуулсан ба тэдгээрийг хууль журамд зааснаар бүрэн гүйцэт, шаардлага хангасан байдлаар цахимжуулсан эсэх талаар мэдээллийн сангаас шалган, баталгаажуулсан болно.

Дээрх бүртгэлийн ИУБ маягтын А талыг иргэний нэрийн эхний үсгээр галиглан, улсын бүртгэлийн нэгдсэн архивт, Б талыг тус хэлтсийн иргэний баримтын архивт хүлээлгэн өгч, санд байршууллаа.

**4.2 Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2022 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 4/522 тоот “Иргэний улсын бүртгэлийн тухай” албан бичгийн биелэлтийн талаар:**

Улсын бүртгэл хөтлөх явцад тухайн иргэний улсын бүртгэлийн архивын эх нотлох баримт бичиг хоорондоо зөрүүгүй, зөвхөн цахим сангийн мэдээлэл зөрүүтэй бол иргэний улсын бүртгэлд нэмэлт, өөрчлөлт оруулахаар холбогдох

нотлох баримтыг ирүүлснийг үндэслэн иргэний улсын бүртгэлд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг шийдвэрлэнэ гэсэн чиглэлийн дагуу нийт 251 иргэний мэдээллийг цахимжуулан иргэний бүртгэлийн зөрчлийг арилгасан.

Мөн иргэний улсын бүртгэлийн эх нотлох баримт бичиг хоорондоо зөрүүтэй, иргэний улсын бүртгэлийн архив болон цахим мэдээллийн санд иргэний холбогдох мэдээлэл, эх нотлох баримт бичиг байхгүй, зөрүүтэй 90 иргэний өргөдөл, хүсэлтийг хяналтын байцаагчид шилжүүлэн шийдвэрлүүлсэн байна.

#### **4.3.Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2022 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 10/1536 дугаар албан бичгийн биелэлтийн талаар:**

Лавлагааны тоон мэдээг чиглэлд тусгагдсан хугацаанд нь [ya.munkhtulga@burtgel.gov.mn](mailto:ya.munkhtulga@burtgel.gov.mn) хаягаар, ИУБ маягтын А талыг эх хувиар нь нийт 11 удаа хүргүүлсэн байна.

#### **4.4.Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2022 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 1543 дугаар улсын байцаагчийн дүгнэлтийн биелэлтийн талаар:**

0-16 насны хүүхдийн төрсний бүртгэлд засвар, өөрчлөлт оруулах тухай Хяналтын улсын ахлах байцаагч Ч.Эрдэнэчимэгийн дүгнэлтийн дагуу 121 хүүхдийн бүртгэлийг архивийн цахим санд цахимжуулан, Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд бүрэн тусгасан.

#### **4.5.Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2022 оны 05 дугаар сарын 24-ны өдрийн 4/4585 тоот “Иргэний үнэмлэхийн бүртгэл хөтлөх тухай” биелэлтийн талаар:**

Чиглэлд дурдсан Иргэний үнэмлэхийн бүртгэл хөтлөхөд анхаарах асуудлыг холбогдох хууль, журам, Засгийн газрын тогтоолын дагуу хэрэгжүүлэн ажиллаж байна. Тус чиглэлийн 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдөр хүлээн авч, нийт улсын бүртгэгч нарт байгууллагын дотоод хуралдаанаар танилцуулан, мэргэжил арга зүйгээр хангалаа Тайлант хугацаанд өссөн дүнгээр 3277 иргэний үнэмлэхийн бүртгэл хөтлөн иргэдэд олголт хийсэн байна.

#### **4.6. Улсын бүртгэлийн ерөнхий газрын Иргэний улсын бүртгэлийн газрын даргын 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 4/2584 тоот албан бичгийн биелэлтийн талаар:**

Иргэний улсын бүртгэлийн газраас 2023 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн онлайн сургалтаас өгсөн үүрэг даалгаварын дагуу 100 шейр дотоод сүлжээнд байршуулсан Баянхонгор аймагт бүртгэгдсэн 668 иргэний цахим үнэмлэхний зураг

тулгалтыг нэг бүрчлэн шалгаж дуусгасан ба зураг зөрөөтэй гэх зөрчил байхгүй байсан.

Уг ажлын талаарх илтгэх хуудсыг цахим шуудангаар [b.otgon@burtgel.gov.mn](mailto:b.otgon@burtgel.gov.mn) хаяг руу хугацаанд нь хүргүүлсэн.

#### **4.7. Улсын бүртгэлийн ерөнхий газрын Иргэний улсын бүртгэлийн газрын даргын 2022 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн 4/6527 тоот албан бичгийн биелэлтийн талаар:**

2023 онд E-MONGOLIA-гаар 16 үндэсний энгийн гадаад паспорт, 1 иргэний үнэмлэх захиалагдаж иргэнд олгогдсон байна. Харин иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэл 5 дугаар сарын байдлаар E-MONGOLIA-аар 14 хүсэлт илгээгдэж, 2 бүртгэл баталгаажиж, 12 бүртгэлийг бүртгэхээс татгалзсан бол үүнээс хойш цахим хүсэлт ирүүлээгүй байна.


#### **4.8. ИУБГ-аас өгсөн үүрэг даалгавар чиглэлийн талаар:**

1. Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлэхэд учирч болох эрсдлийг тодорхойлж ирүүл гэсэн даалгаврын биелэлтийг заасан хугацаанд нь гаргаж Хэлтсийн даргын 2023 оны 10 сарын 24-ны өдрийн албан бичгээр [n.natantsetseg@burtgel.gov.mn](mailto:n.natantsetseg@burtgel.gov.mn) хаягаар хүргүүлсэн.

2. Энгийн гадаад паспортын олголтыг багасгах талаар тодорхой арга хэмжээ зохион байгуулж, биелэлтийг тайлагнах талаар ИУБГ-аас өгсөн чиглэлийн дагуу хийж хэрэгжүүлсэн ажлыг “Илтгэх хуудас”-аар [b.narangerel@burtgel.gov.mn](mailto:b.narangerel@burtgel.gov.mn) хаяг руу илгээж тайлагнасан.

Манай хэлтсийн тухайд 2023 оны 01 сарын 01-нээс 2023 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн дотор нийт **4265** үндэсний энгийн гадаад паспортын захиалга, олголтын үйлчилгээ үзүүлснээс, энгийн гадаад паспорт **1851**, цахим гадаад паспорт **2414** байна. Мөн 2023 оны 03 сарын 03-ны өдрөөс эхлэн цахим гадаад паспортын захиалга авч эхэлсэн байна.

## Тоон мэдээг графикаар харьцуулан харуулбал;



Цахим гадаад паспорт хэрэглээнд нэвтэрч эхэлсэнтэй холбогдуулан цахим гадаад паспортыг түлхүү захиалуулах талаар иргэдэд цахим паспортыг таниулан сурталчлах арга хэмжээг өдөр тутамдаа хийж байгаа ба үүний үр дүнд 2023 оны 05 сараас цахим гадаад паспортыг захиалах хувь нэмэгдсэн байна.

### Цахим гадаад паспортыг захиалахад нөлөөлж буй хэд хэдэн хүчин зүйл

Ажиглалт болон бүртгэл мэдээлэл дээр тулгуурлан гадаад паспорт захиалж байгаа нөхцөлд байдалд /аймгийнхаа тухайд/ дүгнэлт хийхэд Цахим гадаад паспортын хэрэглээ, ач холбогдлыг иргэд ойлгож байгаа боловч хөдөө орон нутгийн иргэдийн тухайд цахим паспортын үнийг төлөх эдийн засгийн чадавхи, нас, хандлага, паспорт захиалах зорилго, шалтгаан ихээхэн нөлөөлж байна гэж үзэж байна. **Тодруулбал,**

1. **Цахим паспортын үнэ:** Энгийн гадаад паспортын үнэ нь арай хямдхан гэдэг утгаар энгийн гадаад паспортыг захиалж байна.

#### 2. Паспортыг захиалах зорилго, шалтгаан.

2.1. Насанд хүрээгүй буюу бага насны хүүхдүүд эцэг эх, асран хамгаалагчийн хамт аялалд явах зорилгоос гадна улсын болон орон нутгийн чанартай тэмцээн уралдаанд орох шалтгаанаар энгийн гадаад паспортыг захиалж байна.

2.2. Хил залгаа буюу визгүй зорчих оронд цөөн хоногоор аялах зорилгоор явах гэж байгаа ахмад настнууд энгийн гадаад паспортыг захиалж байна.

2.3. Харин бизнесийн болон ажлаар, аялалаар явах зорилготой иргэд цахим гадаад паспортыг захиалж байна.



❖ Ажиглалт болон бүртгэл мэдээлэл дээр тулгуурлан хийсэн энэхүү дүгнэлтдээ үндэслэн цахим гадаад паспортын захиалгыг нэмэгдүүлэх, энгийн гадаад паспортын олголтыг бууруулах чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Үүнд:

1. Үйлчилгээ авч байгаа иргэн бүрт гадаад паспортын олон улсын хэрэглээ, ач холбогдлыг хүн бүрт тайлбарлан таниулах ажлыг тогтмол хийж байна.

2. Энгийн гадаад паспортыг захиалж буй иргэдэд /насны сегменчлэл/, тэр дундаа сургуулийн хүүхдүүдэд болон биеийн тамирын багш, дасгалжуулагч нарт цахим гадаад паспортын олон улсын хэрэглээ, ач холбогдлыг таниулах арга хэмжээг 9 сарын 10-11-ны өдрүүдэд зохион байгуулав.

3. Бизнес эрхлэгчдэд буюу төвлөрсөн хдалдааны зах дээр лангууны наймаа хийдэг иргэдэд зориулан цахим гадаад паспортын олон улсын хэрэглээ, ач холбогдлыг таниулах сурталчилгааг “Баруун бүс худалдааны төв” дээр мөн 9 сарын 5-нд зохион байгуулав.

4. Энгийн гадаад паспорт хэрэглээнээс гарч байгаа тул цахим гадаад паспортыг захиалах нь таны хэрэгцээг бүрэн хангахын зэрэгцээ олон улсын стандарт шаардлагыг хангаж аялахад таньд саадгүй байна гэсэн ухуулга сурталчилгааг тогтмол хийхийг Сумын улсын бүртгэгч нартаа үүрэг болгов.

❖ **Эдгээр ажлын үр дүнд 9-11 саруудад цахим гадаад паспортын захиалга эрс нэмэгдсэн байгаа нь бүртгэлийн тоон дүнгээс харагдаж байна.**

❖ **Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар:**

1. 2023 оны 09 сарын 25-наас эхлэн өдөр бүр нэг байгууллага, төвлөрсөн үйлчилгээний төвүүд дээр очиж тоон гарын үсэг болон цахим гадаад паспортын, мөн И-Монголиа цахим платформын үйлчилгээний хэрэглээг сурталчлах ажлыг аймгийн ЗДТГ-ын Цахим хэлтэстэй хамтран зохион байгуулахаар төлөвлөсөн болно.

Энэ арга хэмжээний үр дүнд цахим гадаад паспортын захиалга нэмэгдэнэ гэж үзэж байна.

## **ТАВ. ИРГЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР**

### **5.1. Иргэний улсын бүртгэлийн үйлчилгээний тоон мэдээ:**

Монгол Улсын Иргэний хууль, Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Иргэний улсын бүртгэлийн тухай хууль, Гэр бүлийн тухай хууль болон улсын бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой хууль, дүрэм, журмыг бүртгэлийн өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдлөг болгон ажиллаа.

2023 онд хийсэн нийт иргэний улсын бүртгэлийг эрх үүсэх, өөрчлөгдөх, дуусгавар болох төрлөөр нь ангилвал:

**1. Эрх үүсэх, дуусгавар болох бүртгэл:**

Төрсний бүртгэл -1504  
 Гэрлэсний бүртгэл-314  
 Гэрлэлт дуусгавар болсны бүртгэл-47  
 Нас барсны бүртгэл-487



**2. Өөрчлөлтийн бүртгэл**


Үрчилсний бүртгэл-22  
 Эцэг /эх/ тогтоосны бүртгэл-79  
 Овог, нэр өөрчлөлтийн бүртгэл-95  
 Регистрийн дугаар өөрчлөлт-3

95

**Иргэний улсын бүртгэлийн 2023 оны тоон мэдээг төрлөөр нь дараах графикаар харуулбал;**







## 5.2. Иргэний улсын бүртгэлийн архивын чиглэлээр:

- Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 10/05 тоот “Чиглэл, зөвлөмж хүргүүлэх тухай” албан бичгийн биелэлтийн талаар:

“Чиглэл зөвлөмж хүргүүлэх тухай” Улсын Бүртгэлийн Ерөнхий Газрын 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 10/05 дугаартай албан бичгээр ирүүлсэн чиглэл, зөвлөмжийн дагуу Хэлтсийн БНШК-ын бүртгэлийн үйл ажиллагааны явцад үүссэн баримт бичгийн хадгалах хугацаа нь дууссан, мэдээлэл лавлагаанд ашиглагдахгүй, архивын санд хадгалах шаардлагагүй устгах баримтын жагсаалтын дагуу баримтыг устгах ажлыг хийлээ. Үүнд:

- Иргэний үнэмлэх дахин олголтын анкет бүртгэлийн дэвтэр /2019 оны 6586 хуудас бүхий 18 боть/

- Иргэний үнэмлэх дахин олголтын анкет бүртгэлийн дэвтэр /2020 оны 6100 хуудас бүхий 10 боть/

- Иргэний үнэмлэх олгосон хуудас /2020 оны 4260 ширхэг маягт/

- Улсын бүртгэлийн мэдээллийн сангаас олгосон лавлагааг үндэслэн дахин гэрчилгээ олгосон бүртгэлийн дэвтэр /3 боть хадгаламжийн нэгж 23 хуудастай/

Нийт 31 ширхэг хадгаламжийн нэгж 16969 хуудас бүхий устгах баримт бичгийг 2023 оны 03 дүгээр сарын 30-ний өдрийн 18 цаг 20 минутанд БНШК-ын гишүүд, архиваас гарган, ажлын хэсгийн ахлагч, гишүүд иргэний бүртгэлийн тасгийн дарга, улсын ахлах бүртгэгч У.Золзаяа, Хяналтын улсын байцаагч С.Мэндбаяр, хуулийн этгээдийн улсын бүртгэгч Д.Отгонсүрэн, Архивч М.Дашням, нар нь тус хэлтсийн бүрэн шатааж дуусгав. Устгалын явцад Улсын бүртгэлийн ерөнхий газрын дэргэдэх Улсын бүртгэлийн нэгдсэн архивын БНШАЗК-ын дүрмийг баримтлан устгах баримтын аюулгүй ажиллагааг ханган ажиллалаа. Ямар нэгэн зөрчил гараагүй болно.

- Архивын Мэдээлэл лавлах системд 2007-2009 онд төрсөн Баянбулаг сумын харъяат 110 иргэний ХААТР-11, Заг сумын харъяат 105 иргэний ХААТР-11 маягтуудыг цахимжуулж, цахим архивын сан хөмрөгийн баяжилтыг хийлээ. 2007-2009 онд төрсөн иргэдийн ХААТР маягыг цахимжуулснаар иргэний мэдээллийг шалгах, нягтлахад шууд сангаас харахад бэлэн байдлыг хангахын зэрэгцээ улсын бүртгэгч дараагийн бүртгэл хийхдээ заавал архивч руу залгаж архивчаас асуудаг, архивын сан хөмрөгөөс хайлт хийлгэж, архивчийн ажлыг нэмэгдүүлж, ачаалал үүсгэж байдаг явдал буурна гэж харж байна.

### **5.3.Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн талаар:**

Хяналтын Улсын ахлах байцаагчийн 2023 оны 7 дугаар сарын 18-ны өдрийн 4865 дугаарт дүгнэлт гарснаар тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгчийн шийдвэрлэх асуудлын хүрээнд өргөдөл гомдол шийдвэрлэх ажил ихээхэн нэмэгдсэн. Иргэний улсын бүртгэлийн цахим санд иргэний мэдээлэл зөрүүтэй, буруу, огт ороогүй гэх үндэслэлээр иргэний улсын бүртгэлийн мэдээллээ засуулахтай холбоотойгоор гаргасан өргөдөл хэлтэст ирж буй өргөдөл гомдлын дийлэнх хувийг эзэлж байна.

2023 оны Иргэний улсын бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой нийт 58 өргөдөл хүлээн авснаар хуулийн хугацаанд шийдвэрлэсэн 32, хяналтын улсын байцаагч руу шилжүүлсэн 5, хуулийн хугацаандаа шийдвэрлэгдэхээр судлагдаж байгаа 21 өргөдөл байна.

## **ЗУРГАА. БУСАД АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД:**

### **6.1. Улсын бүртгэгч нарыг мэргэжлийн арга зүйгээр хангаж ажилласан талаар:**

- Иргэний улсын бүртгэлийн газраас ирүүлсэн чиглэл, зөвлөмж бүрийг цаг тухайд нь улсын бүртгэгч нартаа дамжуулан мэдээллэж, арга зүйгээр ханган ажиллаж байна.

Мөн төрсний бүртгэлийг бүртгэхдээ нэрийн толийг бүрэн дүүрэн ашиглаж байх, нэрийг сонгохдоо нэрийн галигийг давхар харж хянаж байж нэрийг сонгох талаар өдөр тутамдаа зөвлөгөө өгч, гарсан алдаа бүрийг даруй засуулж баталгаажилтыг хийж байна.

- Улсын бүртгэлийн үйлчилгээг орон нутаг дахь анхан шатны нэгжид шилжүүлж улсын бүртгэлийн үйлчилгээний шат дамжлагыг багасгах, мөн улсын бүртгэгч нарын ажлын ачааллыг тэнцвэржүүлэх зорилтын хүрээнд Улсын бүртгэгч нарт иргэний үнэмлэхний баталгаажуулалтад нэмэх бүртгэл болон зураг засврын

бүртгэл хийх эрхийг 2023 оны 08 сард нээлгүүлснээр хэлтсийн 2 улсын бүртгэгчид ажлын давхардал, ачаалал үүсгээд байсан алдааг залрууллаа.

- Улсын бүртгэгч нарт шинээр нэмэгдсэн дээрх бүртгэлүүдтэй холбоотойгоор мэргэжлийн арга зүйгээр хангасан чиглэл зөвлөмжийг Хэлтсийн даргын албан бичгээр хүргүүлж, мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллалаа.


## Гурав. АРХИВЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

### 3.1 Иргэний бүртгэлийн архив:


Иргэний баримтын архивын хувийн хэргийн санд 2023 оны жилийн эцсийн байдлаар:

- Хувийн хэргийн нэгдсэн санд 114272 хувийн хэрэг
- Иргэний гэр бүлийн байдлын бүртгэлийн санд 5103 ширхэг хадгаламжийн нэгж
- Үндэсний энгийн гадаад паспортын санд 155 ширхэг хадгаламжийн нэгж тус тус хадгалагдаж байна.

Улсын бүртгэгч нараас 2023 оны жилийн эцсийн байдлаар иргэний улсын бүртгэл хөтөлсөн нийт 12134 ширхэг ИУБ маягтыг “Архивт маягт хүлээлцэх бүртгэл” болон нэрийн жагсаалтын хамт хүлээн авч цагаан толгойн үсгийн дарааллаар галиглан, архивт хүлээн авч хувийн хэргийн нэгдсэн санд нэг бүрчлэн байршуулж хувийн хэргийн баяжилтыг хийж ажиллав. Үүнийг дараах графикаар дэлгэрэнгүй харуулбал:



Жилийн эцсийн байдлаар өөр аймаг, хотруу шилжин явсан нийт 190 иргэний хувийн хэрэг, хаатр, маягтыг жагсаалтын хамт албан бичгээр хүргүүлж ажилласан байна. Тухайлбал:



Мэдээллийн санд мэдээлэл нь зөрүүтэй иргэдийн хувийн хэрэг, болон архивын цаасан эх нотлох баримттай тулгах шаардалагатай тохиолдолд эрх бүхий албан тушаалтан Хэлтсийн дарга, Тасгийн дарга, Хяналтын улсын байцаагч, Улсын бүртгэгч нарт “Архиваас түр ашиглуулахаар олгосон иргэний баримтын бүртгэлийн дэвтэр”-ээр нийт 511 иргэний хувийн хэрэг, 180 ширхэг бүртгэлийн дэвтрийг архивын сангаас гаргаж, буцаан хүлээн авч санд байршуулан ажилласан. Иргэний улсын бүртгэгч нараас 2022 онд хөтлөгдсөн бүртгэлийн дэвтэр, бүртгэл хийхэд бүрдүүлсэн баримт бичгийн бүрдүүлбэрийг архивт хүлээн авахдаа баримтын үдэлт, дугаарлалт, нүүр, ашиглалтын хуудас, дотоод товьёг, баталгааны хуудас, бүртгэгчийн гарын үсэг зэргийг нягтлан шалгаж нийт 350 ширхэг хадгаламжийн нэгжийг “2022 оны бүртгэл, нотлох баримт хүлээлцэх” жагсаалтаар архивт хүлээн авч хаягжуулж, хадгаламжийн нэгж үүсгэн тавиурт байршуулсан.

### **3.2. ХУУЛИЙН ЭТГЭЭД, ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН БҮРТГЭЛ**

Хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн дарга, улсын ахлах бүртгэгч болон улсын бүртгэгчид нь Монгол улсын Үндсэн хууль Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Иргэний Улсын бүртгэлийн тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, Архивын тухай хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль, Иргэний улсын бүртгэл хөтлөх журам, болон холбогдох бусад дүрэм, журам, чиглэлийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон Иргэний эрхийг бүрэн ханган ажиллаж байна.

Тайлант хугацаанд Хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр хийсэн ажлыг дараах байдлаар ирсэн он цагийн дарааллаар тайлагнаж байна.

**НЭГ.ЕРӨНХИЙ ГАЗРААС БОЛОН УДИРДЛАГААС ӨГСӨН ЧИГЛЭЛ,  
ЗӨВЛӨМЖ, ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТИЙН ТАЛААР:**

**Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хяналтын улсын байцаагчийн 2022 оны  
03 дугаар сарын 02-ны өдрийн 1500 дугаар дүгнэлтийн талаар:**

Хяналтын улсын байцаагчийн дүгнэлтийн дагуу 2023 оны 1 дүгээр сараас 11 дүгээр сарын 24-ний өдрийн байдлаар **82** бүртгэлд засвар өөрчлөлт орууллаа. Үүнээс 2023 оны 05-р сар дуустал улсын ахлах бүртгэгч П.Бүжинлхам **19**, Улсын ахлах бүртгэгч У.Золзаяа 6 дугаар сараас эхлэн **63** хувийн хэргийн цахимжуулалтад засвар өөрчлөлт оруулсан байна. Дээрх засвар өөрчлөлтүүдээр цахимжуулалтаар гарсан алдаа зөрчлийг арилгасан болно.

Мөн цаг үеийн үүрэг даалгавар болгосон “Нягтлан шалгаж, засвар өөрчлөлт хийх тухай” албан бичгүүдийн биелэлтийг тоо баримт, жагсаалтын дагуу Илтгэх хуудсаар тухай бүрт нь хүргүүлж ажилласан.

Баянхонгор аймгийн хувьд улсын бүртгэгч нартайгаа хамтран, архивт хадгалагдаж байгаа хувийн хэргийн нотлох баримтыг цахимд хадгалагдсан нотлох баримттай нь тулган шалгаж, ямар нэгэн зөрчилтэй хувийн хэргүүдийг ялган, тус дүгнэлтээр засах боломжтой цахимжуулалтын болон дугаарлалтын алдааг засах ажлыг эрчимжүүлэн ажиллаж байна.

Мөн хувийн хэргийг хаах шаардлагатай байгаа болон **зайлшгүй** дүгнэлт гаргах шаардлагатай хувийн хэргүүдийг ялган хяналтын улсын бүртгэгчид шилжүүлэн ажиллаж байна. Жишээлбэл: Үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээн дээр зөвхөн хашаа бүртгэж гэрчилгээ олгосон, улсын бүртгэлийн дугаар давхардуулан бүртгэж байсан гэх мэт. Эдгээр нь голдуу 2000 аад оны бүртгэл дотроос илрэн гарч ирсэн зөрчлүүд байна.

2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Баянхонгор аймгийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд нийт **19943** хувийн хэрэг хадгалагдаж байгаагаас одоогийн байдлаар засвар өөрчлөлт хийх шаардлагатай байх магадлалтай гэсэн **480** орчим хувийн хэргийг дахин нягтлан шалгаж, засвар өөрчлөлт оруулах эсэхийг шийдвэрлэн, зөрчлийг арилгах ажлыг Улсын ахлах бүртгэгч У.Золзаяа гүйцэтгэн ажиллаж байна.

Мөн мэдээллийн санд зөрчилтэй өмчлөгчийн мэдээллийг засаж, зөрчлийг арилгаж байна. Жишээ нь Г-0320001731 дугаарт иргэн П.Болдмаа /ВЭ65112865/-г



2 удаа өмчлөгчөөр хадгалаад, харин А.Батмөнх /ВЭ60100773/-ийгөмчлөгчөөр оруулаагүй байсныг залруулан хадгалсан.

Засвар өөрчлөлтийн тайлан мэдээг нэгдсэн журмаар 2022-2023 оны байдлаар илтгэх хуудас, жагсаалтын хамт [e.suvderdene@burtgel.gov.mn](mailto:e.suvderdene@burtgel.gov.mn) хаягаар хугацаанд нь хүргүүлсэн.

Мөн 10, 11-р сард батлагдан ирсэн маягтын дагуу засвар өөрчлөлт оруулсан бүртгэлийн мэдээг [e.suvderdene@burtgel.gov.mn](mailto:e.suvderdene@burtgel.gov.mn), [edkhourungu@burtgel.gov.mn](mailto:edkhourungu@burtgel.gov.mn) хаягуудад хугацаанд нь хүргүүлээ.

**Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн программын “Мэдээ мэдээлэл”-д 2022 оны 12 сарын 21-ний өдөр байршуулсан “Бүх аймгууд улсын бүртгэлийн хэлтсийн хэлбэр, даргын бүртгэлийг үнэн зөв бүртгэх, үйл ажиллагааны чиглэлийг УБЕГ-ын чиглэлтэй ижил болгож бүртгэх” талаар Д.Дэлгэрсайхан даргаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн талаар:**

Тус чиглэлийг хэлтсийн дарга болон нягтлан бодогч нарт танилцуулан, холбогдох материалыг бүрдүүлж, 2023 оны 01 сарын 06-ны өдөр тус хэлтсийн хуулийн этгээдийн улсын бүртгэлийн эрхлэх үйл ажиллагааны чиглэлийг УБЕГ-ын үйл ажиллагааны чиглэлтэй ижил болон мэдээлэлд өөрчлөлт оруулах бүртгэлийг бүртгэж, холбогдох материалыг цахимжуулж дуусгасан. Үүрэг даалгаврыг биелүүлж ажилласан талаарх хариуг хуулийн этгээдийн улсын бүртгэгч нарын нэгдсэн [legal Entity](#) чат группээр хүргүүлэн ажилласан.



**Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газрын 2023 оны 01 сарын 11-ний өдрийн 5/334 тоот, 2023 оны 05 сарын 08-ны өдрийн 4/4386 тоот албан бичгүүдийн биелэлтийн талаар:**

Хуулийн этгээдийн улсын бүртгэлтэй холбоотой хууль тогтоомж, журмыг судлах, түүнд нийцүүлэн үнэн зөв бүртгэл хөтлөх, хуулийн этгээдийн цахим мэдээллийн санд алдаагүй, зөв бүртгэх, эх нотлох баримтын цахимжуулалтыг бүртгэл хийсэн даруйдаа хийж байна.

Мөн харилцааны соёл болон анхаарах бусад асуудлаар ирүүлсэн чиглэлийн дагуу хуулийн этгээдийн улсын бүртгэлийг бүртгэхдээ УБ-03, УБ-12 маягтыг үнэн зөв, бүрэн гүйцэт бөглүүлж, сайтар шалган хүлээн авч байна.

Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч, хувьцаа эзэмшигчийн тоо, эрх бүхий этгээд, гүйцэтгэх удирдлага зэрэгт өөрчлөлт орж байгаа тохиолдолд өмнөх бүртгэлтэй байсан мэдээллийг идэвхгүй төлөвт оруулж, дахин шинээр бүртгэх мөнхуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т заасан ажлын 15 хоногт бүртгүүлээгүй хугацаа хэтэрсэн тохиолдолд хяналтын улсын байцаагчаар хянуулж, зөрчил хянан шийдвэрлэсэн баримт бичгийг үндэслэн бүртгэж, тухай бүр цахимжуулалтыг хийж ажиллаж байна.

Чиглэлд дурдагдсан 31 төрлийн заалтыг өдөр тутмын бүртгэлийн үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжүүлэн ажиллаж байгаа ба 2023 оны байдлаар **7994** бүртгэл хийсэн ба ямар нэгэн гомдол санал гараагүй.

**Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын даргын 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 6/277 тоот албан бичгийн талаар:**

“Хугацаатай үүрэг өгөх тухай” тусалбан бичгээр ирүүлсэн үл хөдлөх эд хөрөнгийн хэмжээ, үнэ бичигдээгүй буюу алдаатай бичигдсэн дугаар бүхий 17 хувийн хэргийг цахим санд тулган шалгаж, завсар өөрчлөлтийг хийж, тайланг нь “Илтгэх хуудас”-аар 2023 оны 01сарын 11-ны өдөр [edkhourung@burtgel.gov.mn](mailto:edkhourung@burtgel.gov.mn) хаяг руу хугацаанд нь илгээсэн.

**Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 1/602 тоот албан бичгийн биелэлтийн талаар:**

УБЕГ-ын даргын 2023 оны 1/602 дугаарт албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу иргэн өөрийн эд хөрөнгийн мэдээллээ шалгуулах хүсэлтийг хүлээн авч, цаг тухай бүрт нь шуурхай шийдвэрлэхийн зэрэгцээ холбогдох зөвлөгөөг өгч, эрх зүйн туслалцаа үзүүллээ. Иргэдийн гаргаж буй хүсэлтийн дийлэнх хувь нь өөрийн өмчилж байсан газар, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрх шилжсэн бүртгэлээ хийлгүүлээгүй 10, 20 жил болсон асуудал байлаа.

Хүүхдийн мөнгөн тэтгэмж олгохтой холбоотой иргэдийн зөрүүтэй мэдээллийг засах, зөв болгож бүртгэх, улсын бүртгэл болон бусад төрөлжсөн

бүртгэлийн мэдээллийг нэг болгох, бүртгэл мэдээллийн зөрүүг арилгаж хамтран ажиллах чиглэлээр ажлын хэсэг байгуулагдан хамтран ажилласан.

Холбогдох тайланг Хөдөлмөр, халамж үйлчилгээний газарт хүргүүлэн нэгтгэж, аймгийн Засаг даргад 2023 оны 05 сарын 01-ны дотор тайлагнасан ба хэдэн иргэний асуудлыг хэрхэн яаж шийдвэрлэсэн талаар УБЕГ-т өдөрт 2 удаа мэдээ хүргүүлж ажилласан.

Тус ажлын үеэр **53** иргэний асуудлыг шийдвэрлэсэн ба улсын бүртгэгч **А.Оюунсүвд** хариуцан ажилласан болно.

**Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын даргын 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн 5/1827 тоот албан бичгийн талаар:**

Монгол банк нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн албан татвар төлөх этгээдэд хамаарахгүй болохыг албан бичигт дурдсаны дагуу эд хөрөнгийн бүртгэл хөтөлж байгаа нийт 7 бүртгэгчид танилцуулан, бүртгэлийн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Өнөөдрийн байдлаар буюу 2023 онд тус бүртгэлийн үйлчилгээг авахаар Баянхонгор аймгийн Эд хөрөнгийн бүртгэлийн тасагт мэдүүлэг гаргаагүй байна.

**Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын даргын 2023 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 5/1854 тоот албан бичгийн талаар:**

Тусалбан бичгээр ирүүлсэн “Хувийн хэрэг хаах” үйлчилгээг ePRS системээр хүлээн авч боловсруулалт хийсэн боловч өмчлөгчийн төлөв өөрчлөгдөөгүй “Өмчилсөн” төлөвтэй хэвээр харагдаж байгаа гэх 21 хувийн хэргийг цахим санд шалгаж, засвар өөрчлөлтийг хийсэн.

Уг албан бичгийн хавсралт жагсаалтаар ирүүлсэн **36** хувийн хэргээс гадна УБЕГ-ын даргын 2021, 2022 оны тушаалаар “Хувийн хэрэг хаах” бүртгэл хийгдсэн **74** бүртгэл, нийт **110** бүртгэлийг тулган шалгаж, холбогдох өөрчлөлтийг хийж, тайланг [e.suvderdene@burtgel.gov.mn](mailto:e.suvderdene@burtgel.gov.mn) хаягаар илгээж тайлагнасан.

**Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2023 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 1/2559 тоот албан бичгийн биелэлтийн талаар:**

УБЕГ-ын даргын 2023 оны 1/2559 дугаарт албан бичгээр ирүүлсэн чиглэлтэй танилцаад улсын бүртгэгч нарт Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай

хуулийн 30 дугаар зүйлд заасан эрхийн улсын бүртгэлийн тусгай тэмдэглэл, мөн тус хуулийн 31 дүгээр зүйлд заасан урьдчилсан тэмдэглэлийн бүртгэлийг бүртгэхдээ хуулийг зөв ойлгож хэрэглэх талаар арга зүйн зөвлөгөө өгч, хууль хяналтын байгууллагаас ирүүлсэн тусгай тэмдэглэл хийх албан бичиг, холбогдох эрх зүйн актуудыг дор бүр нь хугацаа алдалгүй бүртгэж, цахимжуулан ажиллах талаар тогтмол үүрэг даалгавар өгөн хяналт тавин ажиллаж байна.

2023 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн байдлаар Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нийт **328** тусгай тэмдэглэлийн бүртгэл хөтөлсөн байна. Тусгай тэмдэглэлийн 78 нь шүүх болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас, 250 нь МИК активаас ирсэн байна. Дээрх бүртгэлүүдийг С.Баярмаа 7, П.Бүжинлхам 13, У.Золзаяа 6, А.Оюунсүвд 62, С.Авирмэд 64, Т.Мягмарсүрэн 176 тус тус бүртгэж, цахимжуулсан байна.

### **Эд хөрөнгийн улсын бүртгэлийн газрын даргын 2023 оны 04 дугаар сарын 07-ны өдрийн 5/3231 тоот албан бичгийн биелэлтийн талаар:**

Чиглэлээр ирүүлсэн зөвлөмж, анхааруулгыг улсын бүртгэгч нарт нэг бүрчлэн тайлбарлан танилцуулж, мэргэжлийн арга зүйн зөвлөгөөг өгч, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйл ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэх, улсын бүртгэлийн болон холбогдох бусад хууль тогтоомжийг зөрчсөн үйлдлийг таслан зогсоох, цаашид хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэг мөр хангаж ажиллах шаардлагыг тавьж, тасгийн дотоод хурлыг сард нэг удаа хийж, үүрэг даалгавар өгч ажиллаж байна.

Тус чиглэлийн 3 дахь заалтад “Улсын бүртгэгч эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдүүлэг /ЭУБ-01 маягт/-ийг хүлээн авахдаа мэдүүлэг гаргагчаар болон өөрөө гарын үсгээ заавал зурж, хүлээн авах.....” гэж анхааруулсны дагуу улсын бүртгэгч нарыг эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цахим систем /ePRS-II/-д мэдүүлэг хүлээн авахдаа мэдүүлэг гаргагчийн хурууны хээг заавал уншуулж мэдүүлэг хүлээн авах талаар чиглэл өгөхийн зэрэгцээ хурууны хээ уншигчийг нь суурилуулж өгч, мэдүүлгийг хурууны хээгээр өмчлөгч, итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр гаргуулан бүртгэл хөтөлж байна.

Хурууны хээ уншигдаагүй тохиолдолд улсын ахлах бүртгэгчид танилцуулан бүртгэл хөтөлж, чиглэлийг чанд мөрдөн ажиллаж байна. Жишээ нь: улсын бүртгэгч А.Оюунсүвд нь 111 бүртгэлийн 92 хурууны хээ уншигдаагүй талаар УАБ-чид танилцуулан ажилласан байна.

**Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын даргын 2023 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн 5/3367 тоот албан бичгийн биелэлтийн талаар:**

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2022 оны А/427 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан Барьцааны гэрээг эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэх хүсэлт /ЭУБ-06 маягт/-ийг үйл ажиллагаандаа хэрэглэж буй банк, банк бус санхүүгийн байгууллагыг нэгдсэн мэдээллээр хангах, маягтад тусгагдсан мэдээллийг нэг мөр ойлгох зорилгоор хүргүүлсэн чиглэлийг Баянхонгор аймагт үйл ажиллагаа явуулж байгаа ХААН банк, ХАС банк, Төрийн банк болон Голомт банк зэрэгт Хэлтсийн даргын албан бичгээр арга зүйн сургалт авах захиалгаа ирүүлэхийг хүссэн албан бичгийг хүргүүлсэн. Үүний үр дүнд мэдээлэл авахаар хүсэлт ирүүлсэн Төрийн банкны аймгийн төвийн 9 эдийн засагчид ажлын байран дээр нь очиж мэдээлэл, сургалт зохион байгуулсан.

Мөн Баянхонгор аймагт үйл ажиллагаа явуулж байгаа Банк бус санхүүгийн 9 байгууллагын эдийн засагч нарт “Барьцааны гэрээ /ипотекийн гэрээ/-г эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэхэд анхаарах зүйл” сэдэвт сургалтыг хэлтсийн хурлын зааланд зохион байгуулсан.

Энэ сургалтын хүрээнд Барьцааны гэрээг эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэх хүсэлт /ЭУБ-06 маягт, ЭУБ-13 маягт/-ийн мэдээллийг нэг мөр ойлгож зөв бөглөж ирүүлэх тал дээр арга зүйн сургалтыг хийж, зөвлөгөөг өглөө.

Сургалтаар улсын бүртгэлийн цахим шилжилтийн хүрээнд хийж хэрэгжүүлж байгаа барьцааны эрхийг цахимаар бүртгэх систем, тоон гарын үсэг олгох, түүний хэрэглээний талаар таницлуулгыг хийлээ. Дээрх сургалтуудыг УАБ У.Золзаяа, УАБ П.Бүжинлхам, улсын бүртгэгч А.Оюунсүвд нар зохион байгуулж ажилласан.

**Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын даргын 2023 оны 05 дугаар сарын 01-ны өдрийн 5/4053 тоот албан бичгийн биелэлтийн талаар:**

Баянхонгор аймагт хамаарах Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн цахим сан /ePRS/-д гэр бүлийн хэрэгцээний зориулалттай өмчлөлийн газрын зориулалт “Ашигласан” гэсэн зориулалтаар бүртгэгдсэн гэх **2117 хувийн хэрэг**, “Эзэмших” гэсэн төлөвтэйгээр бүртгэгдсэн гэх **113 хувийн хэрэг**, нийт **2230** хувийн хэргийн цахим бүртгэлийг шалган цахим мэдээллийн санд холбогдох засвар өөрчлөлтийг хийж, тайланг хэлтсийн даргын гарын үсгээр албажуулан хуулийн хугацаанд нь багтаан [edkhourungu@burtgel.gov.mn](mailto:edkhourungu@burtgel.gov.mn), [e.suvderdene@burtgel.gov.mn](mailto:e.suvderdene@burtgel.gov.mn) хаяг руу илгээж тайлагнав.

**Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2023 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн А/953 тоот албан бичгийн биелэлтийн талаар:**

“Тушаалд өөрчлөлт оруулж, маягтын загвар батлах тухай” А/953 тоот тушаалын дагуу холбогдох байгууллагаас ирүүлсэн 250 бүртгэлийг улсын бүртгэлд бүртгэж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна. Харин 2023 оны 11-р сарын 24-ны өдрийн байдлаар ямар нэгэн түрээсийн гэрээ бүртгүүлэх мэдүүлэг гаргаагүй байна.

**Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын даргын 2023 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 5/4618, 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 5/5065 тоот албан бичгүүдийн биелэлтийн талаар:**

Тус үүрэг даалгаврын УБЕГ-аас ирүүлсэн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн цахим санд нэгж талбарын дугаар ороогүй 991 хувийн хэргийн жагсаалтыг эх нотлох баримттай тулган шалгаж, 2023-06-15-наас 2023-06-22-ны өдрүүдэд ажилласан ба дараах ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

1. Жагсаалтаар ирүүлсэн 991 бүртгэлийг улсын бүртгэлийн дугаараар цахим мэдээллийн санд нотлох баримтыг нэг бүрчлэн шалгаж, цахимжуулсан газар эзэмших, ашиглах гэрчилгээ болон газрын кадастрын зурагт тусгагдсан нэгж талбарын дугаарыг санд тусгасан.
2. Цахим мэдээллийн санд цахимжаагүй, цаасан хэлбэрээр эд хөрөнгийн улсын бүртгэлийн архивт хадгалагдаж байсан, нийтийн зориулалттай орон сууц, үйлчилгээний барилгын үндсэн нотлох баримтын кадастрын зурагт тусгагдсан хаягаар дуудаж, холбогдох хувийн хэргийн мэдээлэлд нэгж талбарын дугаарыг цахимжуулж оруулсан.
3. Нийт 911 бүртгэлээс 312 бүртгэлийн нэгж талбарын дугаарыг цахим санд тусгаж, засвар өөрчлөлт хийсэн.

Харин 679 бүртгэлд нэгж талбарын дугаар тусгагдсан нотлох баримт байхгүй, өмнөх үеийн кадастрын зураг байгаа зарим нэг нь нэгж талбарын дугаар бичигдээгүй байгаа тул засвар өөрчлөлт оруулаагүй болно.

Тус чиглэлийн биелэлтийн талаарх илтгэх хуудсыг [e.suvderdene@burtgel.gov.mn](mailto:e.suvderdene@burtgel.gov.mn) хаягаар хугацаанд нь хүргүүлэн ажилласан.

**Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газрын даргын 2023 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 4/5744 тоот албан бичгийн биелэлтийн талаар:**

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2023 оны 05 сарын 31-ний өдөр баталсан “Улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагааны эрсдэлийг бууруулах ажлын дэд төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх ажлын хүрээнд хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагаатай холбоотой чиглэлд дурдагдсан 7 төрлийн заалтыг уншиж танилцан, бүртгэлийн үйл ажиллагаанд хэрэгжүүлэн ажиллаж байна. Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн портал e-business.mn-ээр ирүүлсэн нэр баталгаажуулах болон бүртгэл хийлгэх хүсэлт хүлээн авч шийдвэрлэсэн нийт 691 үүнээс зөвшөөрсөн 74, татгалзсан 525, баталсан 48, цахим гэрчилгээ 44 хүсэлтийг цаг хугцаанд нь түргэн шуурхай шийдвэрлэж ажилласан.

**Улсын байцаагчийн мэдэгдэл 2023 оны 06 сарын 21-ний өдрийн 13 тоот “Улсын бүртгэлийн мэдээллийн сангийн нууцлал, ашиглалтын талаар” албан бичиг, 2023 оны 08 сарын 02-ны өдрийн 5051 дугаар “Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээллийн санд засвар өөрчлөлт оруулах тухай” Улсын байцаагчийн дүгнэлтийн хэрэгжилтийн талаар:**

Иргэн, хуулийн этгээдээс хуулийн этгээдийн улсын бүртгэлд засвар өөрчлөлт оруулах тухай 8 удаагийн хүсэлтийг хүлээн авч дотоод сүлжээний “Мэдээ, мэдээлэл” цэсэнд байршуулан хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газрын ахлахуудад мэдэгдэж, дээрх хяналтын улсын байцаагчийн “Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээллийн санд засвар өөрчлөлт оруулах тухай” 5051 дүгээр нэгдсэн дүгнэлтээр засвар өөрчлөлт оруулж, зөрчлийг хугацаанд нь засуулж шийдвэрлүүлсэн.

**Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын даргын 2023 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 5/6223 дугаар албан бичгийн биелэлтийн талаар:**

Улсын бүртгэлийн багц хууль, Кибер аюулгүй байдлыг хангах тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль болон Хяналтын улсын ахлах байцаагчийн 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 14 дугаартай мэдэгдлийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд мэдээлэл оруулах, өөрчлөх, боловсруулах, баталгаажуулах, үйл ажиллагаатай холбоотой эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цахим систем

/ePRS/-д бүртгэл хөтлөх архивын үйл ажиллагааны талаар нийт улсын бүртгэгч нарт танилцуулан, бүртгэлийн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

**Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газрын даргын 2023 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 4/6218 дугаар албан бичгийн биелэлтийн талаар:**

Хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөхөд холбогдох хууль тогтоомжийг нэг мөр ойлгон, хэрэгжүүлэх, улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сангийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, нууцлалын аюулгүй байдлыг хангаж ажиллах асуудлын хүрээнд ирүүлсэн зөвлөмж чиглэлд дурдагдсан 7 төрлийн заалтыг уншиж танилцан, улсын бүртгэлийн мэдээллийн сангаас өөрийн чиг үүрэгт хамааралгүй мэдээллийг цуглуулах, үзэх, ашиглах, бусдад мэдээлэх, дамжуулахгүй байхыг чанд мөрдөн ажиллаж байна. Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 12 дугаар зүйлийн 12.6 дахь хэсэгт заасан хягзаартай мэдээллээс иргэн, хуулийн этгээдэд лавлагаа, мэдээлэл өгөхдөө тухайн иргэн, хуулийн этгээд эсхүл, тэдгээрээс олгосон хуульд нийцсэн итгэмжлэлийг үндэслэн бүртгэлийн үйлчилгээг үзүүлж байна. Энэ онд хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр итгэмжлэлээр эрх олгогдсон 8 иргэнд үйлчилсэн байна.

**Улсын бүртгэлийн нэгдсэн архивын газраас ирүүлсэн 2023 оны 06 сарын 30-ний өдрийн 9/6417 тоот, 2023 оны 10 сарын 13-ны өдрийн 9/9329 тоот албан бичгийн биелэлтийн талаар:**

Дээрх чиглэлд дурдагдсан 12 төрлийн заалтыг уншиж танилцан бүртгэлийн үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна. Хуулийн этгээдийн хувийн хэрэг, мэдээлэлд оруулсан өөрчлөлтийн баримт бичигт бүртгэл хийсэн даруйд цахимжуулж, шинээр бүртгүүлсэн хуулийн этгээдийн хувийн хэргийг архивт шилжүүлэхдээ хуулийн этгээдийн хэлбэр тус бүрээр ангилж, хувийн хэргийн дугаарын дарааллын дагуу Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2019 оны А/1050 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан “Хуулийн этгээдийн хувийн хэргийг архивт шилжүүлсэн жагсаалт”-аар, нийт 186, Мэдээлэлд оруулсан өөрчлөлтийн баримт бичгийг архивт шилжүүлэхдээ уг тушаалын 3 дугаар хавсралтаар баталсан “Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийн баримт бичгийг архивт шилжүүлсэн жагсаалт”-р нийт 258, архивын материалыг ажлын 5 хоногийн дотор архивчид хүлээлгэн өгч хэвшсэн.



**Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2023 оны 07 сарын 28-ны өдрийн А/1345, Хуулийн этгээдийн газрын даргын 2023 оны 08 сарын 16-ны өдрийн 4/7456 тоот албан бичгийн биелэлтийн талаар:**

Хуулийн этгээдийг нийтэд мэдээлсэн байдал:

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэгт “Санхүүгийн тайлангаа найм ба түүнээс дээш улирал дараалан гаргаагүй, харилцагч санхүүгийн байгууллагад илгээж баталгаажуулаагүй хуулийн этгээдийг улсын бүртгэлээс хасах талаар санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн улсын бүртгэлийн байгууллага өөрийн цахим хуудсаар нийтэд зарлах бөгөөд зарласнаас хойш 6 сарын дотор бичгээр санал гомдол гаргаагүй, дампуурлын хэрэг үүсгээгүй, санхүүгийн тайлангаа гаргаагүй, шүүхийн шийдвэрээр тогтоогдсон өр, төлбөргүй бол уг хуулийн этгээдийг улсын бүртгэлээс хасна” гэж заасны дагуу Сангийн яамны “Санал хүргүүлэх тухай” 2022 оны 10 сарын 19-ний өдрийн 03/7104 дугаар албан бичгээр дээрх үндэслэлээр улсын хэмжээнд **58630** хуулийн этгээдийн мэдээллийг хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газраас 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн байгууллагын [www.burtgel.gov.mn](http://www.burtgel.gov.mn) цахим хуудсаар болон хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээгээр нийтэд мэдээлсэн.

Аймгийн хэмжээнд дээрх мэдээ, мэдээллийг аймаг болон хөдөө орон нутгийн цахим мэдээллийн сүлжээ, хэлтсийн вэб сайт, facebook группт байршуулж хэлтсийн нийт албан хаагчид шэйр хийж олон нийтэд түгээсэн. Мөн эзэн холбогдогч нь тодорхой хуулийн этгээдэд утсаар мэдэгдэж зөвлөгөө мэдээлэл өгсөн. Аймгийн төрийн сангийн мэргэжилтэн Ш.Гэрэлсүхтэй хамтран ажиллаж тайлан мэдээний зөрчлөө арилгаж, цаашид үйл ажиллагаагаа хэвийн явуулах, улсын бүртгэлээс хасуулахгүй байх тухай хүсэлт нийт **32** хуулийн этгээд өгсөн. Тус хүсэлтийг хүлээн авч мэдээллийн санд бүртгэн, баримт материалыг цахимжуулж хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар мэдэгдсэн.



## Хуулийн этгээдийг улсын бүртгэлээс хассан талаар

Сангийн яамнаас ирүүлсэн 2022 оны “ Санал хүргүүлэх тухай” 03/7104 тоот албан бичгийн хүрээнд санхүүгийн тайлангаа найм ба түүнээс дээш улирал дараалан гаргаагүй, харилцагч санхүүгийн байгууллагад илгээж баталгаажуулаагүй, хуулийн этгээдийн мэдээллийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газраас 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн байгууллагын [www.burtgel.gov.mn](http://www.burtgel.gov.mn) цахим хуудас болон хэлтсийн цахим хуудаст байршуулан нийтэд мэдээлж, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэгт заасны дагуу нийтэд зарласнаас хойш 6 сарын дотор бичгээр санал, гомдол гаргаагүй нийт **34377** хуулийн этгээдийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын А/1345 дугаар тушаалаар улсын бүртгэлээс хассан. Тус жагсаалтад манай аймгийн харьяат **142** хуулийн этгээд хасагдсан. Үүнд: Хувьцаат компани хк-1, Хязгаарлагдмал хариуцлагатай компани /ХХК/-64, Нөхөрлөл /ЗБН/-25, /ББН/-7, Холбоо /ГҮТББ/-1, /НҮТББ/-17, Үйлдвэрчний эвлэл ҮЭБ-2, Хэвлэл мэдээллийн байгууллага /ХМБ/-1, Хоршоо-24 тус тус хасагдсан байна. Тус хуулийн этгээдийн архивын хувийн хэргийг тусгаарлах ажлыг архивчийн хамт зохион байгуулж ажлын тайлан, фото зургийн хамт 2023 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр албан бичгээр Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газарт хүргүүлэн ажилласан. Мөн улсын бүртгэлээс хасагдсан 142 хуулийн этгээдийн нэрийн жагсаалтад орсон хуулийн этгээдээс санхүүгийн тайлан мэдээний зөрчлөө арилгах хүсэлтээ төрийн санд гаргасан, цаашид үйл ажиллагаа хэвийн явуулах хүсэлтэй хуулийн этгээдийн хүсэлтийг хүлээн авч улсын бүртгэлээс хасагдсан бүртгэлийг сэргээх боломжтой талаар Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газраас мэдэгдсэний дагуу “Бодь шар булаг” /3132544/ нөхөрлөл, “Аян замын өртөө” /3128741/ хоршоо, “Хүрэнжинст андууд” /3128318/ ХХК-ний “Улсын бүртгэлээс хасагдсан байх тул бүртгэлийг сэргээж өгнө үү” гэсэн хүсэлтийг хүлээн авч, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газарт уламжлан хүргүүлсэн.

Хүсэлт өгсөн дээрх хуулийн этгээд нь Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2023 оны 11 сарын 02-ны өдрийн А/1710 дугаар “Тушаалын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” тушаалын хавсралтаар “Хуулийн этгээдийн улсын бүртгэлээс хасах тухай” А/1345 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан хуулийн этгээдийн жагсаалтаас хасагдаж, бүртгэл нь сэргээгдсэн тухай мэдээллийг 2023 оны 11 сарын 07-ны өдөр ХЭУГ-аас “Мэдээ, мэдээлэл”-д байршуулж хүсэлт өгсөн хуулийн этгээдүүдэд мэдэгдэх талаар үүрэг даалгавар өгсөн. Хүсэлт өгсөн хуулийн этгээдүүдэд 2023 оны 11 сарын 08-ны өдөр утсаар ярьж мэдэгдсэн.

**Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын даргын 2023 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн 5/7477 тоот албан бичгийн биелэлтийн талаар:**

Улсын бүртгэлийн ерөнхий газрын Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын даргын 2023 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн 5/7477 тоот “Чиглэл хүргүүлэх тухай” албан тоотыг Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн нийт улсын бүртгэгч нарт цахимаар танилцууллаа.

Илтгэх хуудсаа [e.suvderdene@burtgel.gov.mn](mailto:e.suvderdene@burtgel.gov.mn) хаягаар хүргүүлсэн.

д/д	Албан тушаал	Нэр	Танилцуулсан хэлбэр
1	Хэлтсийн дарга	Ц.Мөнхжаргал	цахим
2	Хяналтын улсын байцаагч	Л.Мэндбаяр	цахим
3	ХЭЭХЭУБ тасгийн дарга, улсын ахлах бүртгэгч	У.Золзаяа	цахим
4	Улсын бүртгэгч	Т.Мягмарсүрэн	цахим
5	Улсын бүртгэгч	С.Баярмаа	Цахим
6	Улсын бүртгэгч	С.Авирмэд	Цахим
7	Улсын бүртгэгч	А.Оюунсүвд	Цахим
8	Улсын бүртгэгч	Т.Алтаншагай	Цахим
9	Улсын бүртгэгч	Д.Мягмар	Цахим
10	Улсын бүртгэгч	Д.Отгонсүрэн	цахим

2023 оны 11-р сарын 24-ний өдрийн байдлаар Гадаадын иргэнтэй холбоотой ямар нэгэн бүртгэлийн мэдүүлэг гаргаагүй байна.

**Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын даргын 2023 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн 5/7482 дугаар албан бичгийн биелэлтийн талаар:**

Улсын бүртгэлийн ерөнхий газрын Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын даргын 2023 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн 5/7482 тоот “Санал авах тухай” албан тоотыг Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн нийт улсын бүртгэгч нарт цахимаар танилцуулж, санал авлаа. Үүнд:

1.Нийт улсын бүртгэгч нар “Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг бүрэн дэмжиж байна.

2.Харин тус хуулийн төсөлд “Хувьчлагдсан үл хөдлөх эд хөрөнгийг улсын бүртгэлд бүртгэхэд нотлох баримт байхгүй тохиолдолд шүүхээр өмчлөгч тогтоолгох тухай заалтыг хуульд нэмж оруулах саналтай байна. /Эд хөрөнгийн

эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 12 дах хэсэгт “Хувьчлалын үеийн үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийг анх удаа бүртгэн баталгаажуулах” талаар хуульд тусгайлан оруулж өгөх шаардлагатай байна. Энэ нь өмчлөх эрхээ баталгаажуулах нотлох баримт огт байхгүй, олон эзэмшигч дамжиж шилжсэн, балгас болчихсон, хувьчилсан эзэн нь тодорхой бус зэрэг шалтгаанаас үүдэн иргэдийг шүүхээр өмчлөгчөө тогтоолгох талаар зөвлөгөө мэдээлэл өгөхөөр шүүх зарим үед өмчлөгчөөр тогтоох боломжгүй гэх шийдвэр гаргаж үүнээс үүдэн манай байгууллага шүүхэд хариуцагчаар татагдах нь ихсэж байна/ нэмж оруулах саналыг 2023 оны 08 дугаар сарын 18-ны өдөр албан хэрэг хөтлөлтийн Edoc системээр хүргүүлэн ажилласан.

Мөн ePRS-II” системд нэмэлт өөрчлөлт оруулах” талаар 9 саналыг, нийт 14 саналыг [edkhourungu@burtgel.gov.mn](mailto:edkhourungu@burtgel.gov.mn) хаягаар 2023 оны 05 дугаар сарын 10-нд хүргүүлсэн байна.

**Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2023 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн А/1614 тушаал, Эд хөрөнгийн улсын бүртгэлийн газрын даргын 2023 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн 5/7833 тоот албан бичгийн биелэлт:**

Тус тушаал, болон чиглэлийг нийт улсын бүртгэгч нарт танилцуулан хэрэгжилтийг ханган ажиллаж, 2023 оны 08 дугаар сарын 25-наас 2023 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийг хүртэл нийт **43** хувийн хэрэг хааж бүртгэсэн.

Холбогдох тайлан мэдээг хугацаанд нь [e.suvderdene@burtgel.gov.mn](mailto:e.suvderdene@burtgel.gov.mn) хаягаар хүргүүлсэн.

**Эд хөрөнгийн улсын бүртгэлийн газрын даргын 2023 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 5/9854 тоот албан бичгийн биелэлтийн талаар:**

УБЕГ-ын Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газраас 2023 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн Бодлого төлөвлөлт, дүн шинжилгээний газраас өгсөн зөвлөмжийн дагуу 2023 оны 10 дугаар сараас эхлэн Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйл ажиллагааны сарын мэдээг 10, 11 сард нэгтгэн гаргаж, [e.suvderdene@burtgel.gov.mn](mailto:e.suvderdene@burtgel.gov.mn), [edkhourungu@burtgel.gov.mn](mailto:edkhourungu@burtgel.gov.mn) холбогдох үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Мөн сар бүрийн эд хөрөнгийн бүртгэлийн мэдээ, хувийн хэргийн мэдээг хууль журамд заасан хугацаанд нь үнэн зөв гаргаж, нийт 11 удаа хүргүүлэн ажиллаад байна.


Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн нэгдсэн мэдээ, улсын бүртгэлийн үйлчилгээний орлогын мэдээ, хуулийн этгээдийн архивын мэдээг сар бүрийн 25-ны өдрөөр тасалбар болгон, нийт 11 удаа гарган ХЭУБГазар, Нэгдсэн архивт хүргүүлэн ажилласан. Мөн үнэт цаасны мэдээг 11 удаа гарган хэлтсийн нярав, нягтлан нарт хүлээлгэн өгсөн.

**Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын даргын 2023 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 5/9855, 2023 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 5/10279 тоот албан бичгүүдийн биелэлтийн талаар:**

Баянхонгор аймгийн хэмжээнд Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн, шинээр баригдсан нийтийн орон сууц, авто зогсоол, үйлчилгээ, бусад зориулалттай үл хөдлөх эд хөрөнгийг захиалагч, хөрөнгө оруулагч, худалдан авагчийн нэрсийн жагсаалт /цаашид жагсаалт гэх/, түүнд хавсарган ирүүлсэн холбогдох нотлох баримтуудыг Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн систем /ePRS/-ийн “Бүртгэл” цэсний “Шинээр баригдаж буй орон сууцнууд” цонхонд цахимжуулан, бүртгэхтэй холбогдуулан нийт 110 орон сууцны материалыг архиваас ялган гаргаж, 2023 оны 11 дүгээр сарын 02-ноос эхлэн материалыг ялган тусгаарлаж, дотоод товьёг хийн, цахимжуулалтын бэлтгэл ажлыг хангаж эхэлсэн.

Дотооддоо улсын бүртгэгч нараа зохион байгуулан, улсын бүртгэгч А.Оюунсүвдыг тасгийн даргын өрөөнд тусдаа цахимжуулалтын ажилд дагнан ажиллуулж байна.

Өнөөдрийн байдлаар **60** бүртгэлийн хувийн хэрэг цахимжуулан баталгаажуулсан байна. Холбогдох мэдээг 7 хоног бүрийн Баасан гарагт [e.suvderdene@burtgel.gov.mn](mailto:e.suvderdene@burtgel.gov.mn) хаягаар хүргүүлэн ажиллаж байна.



**Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын даргын 2023 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 5/9879 тоот албан бичгийн биелэлтийн талаар:**

Тус албан бичгийн дагуу 2022 оны 01 дүгээр сарын 01-нээс 2023 оны 10 дугаар сарын 25-ны өдрийг дуустал хугацаанд хийгдсэн засвар өөрчлөлтийг хүснэгтийн дагуу гарган хүргүүлсэн.

Хүснэгтийг 2022, 2023 он гэж 2 янзаар sheet үүсгэн бэлдсэн ба 2022 оны 01 дүгээр сарын 01-ээс 2023 оны 05 дугаар сарын 03-ны өдрийг хүртэлх хугацаанд улсын ахлах бүртгэгч П.Бүжинлхам, 2023 оны 06 сараас өнөөдрийг хүртэл улсын ахлах бүртгэгч У.Золзаяа нар засвар өөрчлөлтийн бүртгэл хийж байна.

Хуулийн этгээд, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн дарга, улсын ахлах бүртгэгчийн ажлыг 06 сард хүлээн авснаас хойш архиваас татан гаргасан байсан **480** гаруй хувийн хэргээс шалгаж эхэлсэн. Тус хувийн хэргүүдийг шалгаж дараах үйл ажиллагааг хийж байна. Үүнд:

-**83** бүртгэлд засвар өөрчлөлтийн програм ашиглан засвар өөрчлөлт хийсэн  
-**89** хувийн хэргийг санд шалгаж, засвар өөрчлөлт хийх шаардлагагүй гэж үзэн архивт шилжүүлсэн.

-Засварын программ ашиглан мэдүүлэг буцаалт **6**-г хийсэн.

-цахим санд дугаарлагдан цахимжсан боловч хувийн хэрэгтээ цаасан нотлох баримт нь хадгалагдаагүй хувийн хэрэг, мөн цахим санд зөв дугаарлаж цахимжуулсан мөртлөө хувийн хэрэгт тусгаарласан материалаа үргэлжлүүлэн дугаарласан гэх мэт зөрчилтэй хувийн хэргүүдийг цэгцлэн архивт хүлээлгэн өгч ажиллаж байна. Цаашид дээрх 480 хувийн хэргийг шалган шийдвэрлэж дуусгахаар төлөвлөн ажиллаж байна.

Тус албан бичгийн дагуу судалгааг [edkhourungu@burtgel.gov.mn](mailto:edkhourungu@burtgel.gov.mn) хаягаар хариуцсан улсын бүртгэгчид хаяглан хугацаанд нь хүргүүлэн ажилласан.

***“/ХМХ /хэвлэл мэдээллийн хэрэгсэл/-ийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг нөхөн бүртгүүлэх тухай” Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн программын “Мэдээ мэдээлэл”-д 2023 оны 11 сарын 08-ны өдөр Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газраас ирүүлсэн үүрэг даалгаврын биелэлтийн талаар:***

Дээрх үүрэг даалгаврын дагуу өөрийн хариуцсан хэвлэл мэдээллийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 20 хуулийн этгээдтэй утсаар холбогдож 2023 оны 12 сарын 01-ний өдрийн дотор өөрийн харьяалагдах улсын бүртгэлийн

байгууллагад очиж, эцсийн өмчлөгчийн бүртгэлээ бүртгүүлэх талаар зөвлөгөө мэдээллийг өгсөн.

Мэдээлэл хүргэсэн талаарх дэлгэрэнгүй жагсаалтыг 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр “Мэдээ, мэдээлэл” цэсэнд байршуулан, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газарт тайлагнасан.

**Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын даргын 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 5/10482 тоот албан бичгийн биелэлтийн талаар:**

Тус чиглэлийн дагуу Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн хувийн хэргийг цахимаар болон цаасан архиваас шүүж, нягтлан шалгах ажилд улсын бүртгэгч Т.Мягмарсүрэнг томилон ажиллууллаа.

Эхний ээлжинд 2018 оны 11 сарын 20-ны өдрөөс өмнө газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээнд "Г" дугаар олгож бүртгэсэн нийт бүртгэлийг нэг бүрчлэн тулган шалгаж, улсын бүртгэлийн дугаараар жагсаалт үйлдэн гаргалаа.

Нийт 338 улсын бүртгэлийн дугаартай бүртгэл байна. Цаашид тус жагсаалтыг Э дугаар олгогдсон эсэхийг нягтлан шалгаж, улсын бүртгэгч нарт хуваарилан хаах бүртгэлийг хийлгэхээр төлөвлөн ажиллаж байна.

11-р сарын байдлаар Г-дугаар хаасан бүртгэл хийгдээгүй, харин зөвлөгөө өгсөн 2 бүртгэл байна.



**Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын даргын 2023 оны 11 дүгээр сарын 21-ны өдрийн 5/10828 тоот албан бичгийн биелэлтийн талаар:**

Чиглэлийг нийт бүртгэгч нартаа танилцуулан, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Мөн УБЕГ-ын Хяналт шалгалтын газраас өмчлөх эрхтэй холбоотой иргэн Оюундэлгэрийн өргөдөл гомдолтой танилцан, бүртгэлийн талаар нь судлан шалгаж, аймгийн шүүхээс холбогдох хариуг авч /тухай үед 2003 онд төрөөс хувьчилсан газрын өмчлөх эрхийн гэрчилгээг хүчингүй болгосон/ албан бичгээр хүлээн авч Хяналт шалгалтын газарт хүргүүлсэн болно.

## **ХОЁР.ХУУЛИЙН ЭТГЭЭД, ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛ**

### **Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр:**

2023 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн байдлаар эд хөрөнгийн нийт **8610** бүртгэлийн мэдүүлэг хүлээн авч, холбогдох бүртгэлийг хөтлөн бүртгэж, цахимжуулан хадгалсан.

### **Анхны бүртгэл нийт 769 бүртгээгдсэнээс:**

- ✓ Шинээр баригдсан орон сууц анх удаа бүртгэж баталгаажуулах - **283**
- ✓ Газраас бусад ҮХЭХ-ийг анх удаа бүртгэж баталгаажуулах - **215**
- ✓ Төрөөс хувьчилсан газрын өмчлөх эрхийг баталгаажуулах - **239**
- ✓ Өмчлөгчийн хүсэлтээр болон гэрээ хэлцлээр бүртгэл салгаснаар шинэ бүртгэл үүсэх -**31**
- ✓ Төрөөс худалдаж авсан үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийг анх удаа бүртгэх –**1**

### **Өмчлөх эрх шилжих гэрээний бүртгэл нийт 1072 бүртгээгдсэнээс:**

- ✓ Худалдах, худалдан авах гэрээ - **727**
- ✓ Бэлэглэх гэрээ - **67**
- ✓ Өв залгамжлал - **116**
- ✓ Хамтран өмчлөгч өөрчлөгдөх - **6**
- ✓ Өмчлөгч өөрт ногдох хэсгээ бэлэглэх - **77**
- ✓ Өмчлөгч өөрт ногдох хэсгээс бэлэглэх - **20**
- ✓ Өмчлөгч өөрт ногдох хэсгээ худалдах – **35**
- ✓ Өмчлөгч өөрт ногдох хэсгээс худалдах –**16**
- ✓ Арилжих гэрээ **4**
- ✓ Шүүхийн шийдвэрээр өмчлөгч өөрчлөгдөх **3**
- ✓ Өмчлөх эрх шилжүүлэх гэрээ **1**

### **Эд хөрөнгийн бүртгэлд өөрчлөлт оруулах бүртгэл нийт 505 бүртгээгдсэнээс:**

- ✓ Эд хөрөнгийн хэмжээ, үнэ, гүйцэтгэл өөрчлөгдөх - **328**
- ✓ Эд хөрөнгийн хаяг өөрчлөгдөх - **101**
- ✓ Өмчлөгчийн овог нэр, регистер өөрчлөгдөх - **9**



- ✓ Үрэгдүүлсэн гэрчилгээ шинээр олгох - **36**
- ✓ Өмчлөгчийн хүсэлтээр бүртгэл салгаснаар хэмжээ өөрчлөгдөх - **26**
- ✓ Гэмтээсэн гэрчилгээ дахин олгох - **2**
- ✓ Эд хөрөнгийн зориулалт өөрчлөгдөх - **3**

**Барьцааны гэрээ болон дуусгавар нийт 6081 бүртгэгдсэнээс:**

- ✓ Барьцаалбартай барьцааны гэрээ - **1112**
- ✓ Барьцаалбаргүй барьцааны гэрээ - **2031**
- ✓ Барьцаалбартай барьцааны гэрээний өөрчлөлт - **49**
- ✓ Барьцаалбаргүй барьцааны гэрээний өөрчлөлт - **20**
- ✓ Барьцааны гэрээний дуусгавар - **2592**
- ✓ Барьцааны үүргийн зарим хэсэг дуусгавар болох - **277**

**Архивын лавлагаа – 183 /Хуулбар -81, Хувийн хэрэг хаах -102/**


**МИК-аас ирүүлсэн барьцаа хөрөнгө чөлөөлсөн болон тусгай тэмдэглэл бүртгэсэн бүртгэл - 250**

2023 оны 11 дугаар сарын 22-ны өдрийн байдлаар өссөн дүнгээр эд хөрөнгийн нийт **8610** бүртгэлийн бүртгэгдэж, мэдээллийн санд цахимжсан байна.

2023 онд УАБ У.Золзаяа **106**, улсын бүртгэгч Т.Алтаншагай **104**, улсын бүртгэгч Д.Мягмар **169**, улсын бүртгэгч А.Оюунсүвд **2767**, улсын бүртгэгч Т.Мягмарсүрэн **2637**, улсын бүртгэгч С.Баярмаа **533**, улсын бүртгэгч С.Авирмэд **2015**, УАБ П.Бүжинлхам **279** бүртгэл тус тус бүртгэсэн байна.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн нийт үзүүлсэн үйлчилгээнээс улсын төсөвт үйлчилгээний хураамж **92,727,066** төгрөгийг, орон нутгийн төсөвт тэмдэгтийн хураамж **7,713,148** төгрөгийг, үл хөдлөх эд хөрөнгө худалдан борлуулсны орлогын албан татвар **306,663,740** төгрөгийг тус тус төвлөрүүлсэн байна.

**Эд хөрөнгийн бүртгэлийг төрлөөр нь ангилан графикаар харьцуулан харуулбал:**



Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 12 дугаар зүйлд зааснаар хуулийн байгууллагын албан бичиг, иргэн хуулийн этгээдийн өргөдөл хүсэлтэд нийт 277 лавлагаа мэдээлэл олгосон байна

Хуулийн этгээдийн лавлагаа 33үүнээс иргэн, хуулийн этгээдэд 24, төрийн байгууллагад 9, хуулбар 42 үүнээс иргэн хуулийн этгээдэд 31, төрийн байгууллагад 11 олгож ажилласан байна.

2023 оны 11 сарын 24-ний өдрийн байдлаар Хуулийн этгээдийн бүртгэлтэй холбоотой аж ахуй нэгжийн мэдээллийг жагсаалтаар төрийн байгууллагад нийт 9 удаа хүргүүлсэн. Үүнд: Санхүү, төрийн сангийн хэлтэст 1 удаа, Аймаг дахь Худалдаа аж үйлдвэрийн танхимд 2 удаа, Нийгмийн даатгалын хэлтэст 2 удаа, Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба 1 удаа, Аймгийн Онцгой комисст 1 удаа, Татварын хэлтэст 1 удаа, Нийгмийн түншлэлийн сүлжээ төрийн бус байгууллагад 1 удаа хүргүүлсэн.

Тайлант хугацаанд Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлтэй холбогдуулан газар өмчлөх эрхийн гэрчилгээ 1129, үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийн гэрчилгээ 1205, нийт 2334 гэрчилгээ бичиж олгосон байна.

### Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр

Тайлант хугацаанд буюу 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдрөөс 2023 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийг хүртэлх хугацаанд хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр үйлчилгээ авахаар ирсэн иргэн, аж ахуй нэгжид дараах бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай, чирэгдэлгүй үйлчилгээ үзүүлж ажилласан байна.

Шинээр бүртгэгдсэн хуулийн этгээд 186, хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийн бүртгэл 258, татан буугдсан бүртгэл 7 хөтөлсөн байна.

2022 оны 11 сарын 26-ны өдрөөс 2023 оны 11 сарын 24-ний өдрийн байдлаар бүртгэгдсэн хуулийн этгээдийн бүртгэлийн төрлийг дараах графикаар дэлгэрэнгүй харуулбал: Үүнд:



Хуулийн этгээдийн улсын бүртгэлтэй холбоотой хууль тогтоомж, журмыг судлах, түүнд нийцүүлэн үнэн зөв бүртгэл хөтлөх, хуулийн этгээдийн цахим мэдээллийн санд алдаагүй, зөв бүртгэх, эх нотлох баримтын цахимжуулалтыг тухай бүрт цахимжуулж цаасан нотлох баримтыг Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2019 оны А/1050 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан “Хуулийн этгээдийн хувийн хэргийг архивт шилжүүлсэн жагсаалт”-аар, нийт 186, Мэдээлэлд оруулсан өөрчлөлтийн баримт бичгийг архивт шилжүүлэхдээ уг тушаалын 3 дугаар хавсралтаар баталсан “Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийн баримт бичгийг архивт шилжүүлсэн жагсаалт”-р нийт 258, архивын материалыг ажлын 5 хоногийн дотор архивчид хүлээлгэн өгч хэвшсэн.

2023 оны 11 дүгээр сарын 24-ний байдлаар, “Колор интерьер дизайн” /5790409/ ХХК, “Плутус вет” /6699022/ ХХК, “Дэвжих өлзийт хишиг” /6900089/ ХХК, “Си Тү трий” ХХК Улаанбаатар хотоос шилжин ирсэн тул хувийн хэргийг хүлээн авч холбогдох бүртгэлийг хөтлөн цахимжуулалт хийж архивруу шилжүүлсэн төлөвт оруулан хувийн хэргийг архивчид хүлээлгэн өгсөн.

“МОУТЗ” /3129225/ ХХК, “Өндөржаргалантын өлзийтын очирт” /3130568/ ХХК, “Өлгий ээж” /3137554/ ХХК, “Баян оргил сүйх” /6407463/ ХХК, “Номгон соёмбо” /3136973/ ХХК, “АБУСА” /3124134/ ХХК, “Эдванс кредит ББСБ” /5971616/ ХХК, “Онгийн янгирт уул” /3142299/ ХХК, “Дүнчүү арвай” /5487307/ХХК, “Ханан улаан хайрхан” /3137678/ ХХК өөр аймаг хотруу шилжин явсан тул холбогдох бүртгэлийг хөтөлж хувийн хэргийг хэлтсийн албан тоотоор хүргүүлж ажилласан.

Тамга тэмдгийн хяналтын дугаар олгосон нийт **229** бүртгэл бүртгэсэн байна. Хуулийн этгээдийн элэгдэж хуучирсан, ашиглах боломжгүй тамга тэмдгийн хураан авах, хяналтын дугаар дахин олгох, хаяж үрэгдүүлсэн тамга тэмдэг, хяналтын дугаарыг дахин олгох, татан буугдсан, хэлбэр, нэр өөрчлөгдсөн хуулийн этгээдийн тамга, тэмдэг нийт **35** ширхэгийг хураан авсан.

“Тамга, тэмдэг хийлгэх үйл ажиллагаанд хяналт тавих, лавлагаа олгох журам”-ын 9-р зүйлийн 9.4-т /...тамга, тэмдэг устгах ажлыг хагас жил тутамд зохион байгуулна/. гэж заасны дагуу эхний хагас жилд хураан авсан тэмдэг нийт 21 ширхэг тэмдгийг устгасан.

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн 226 дугаар тогтоол “Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэг журам”-ын 6.17-т ...төрийн байгууллагын хураалгасан тамгыг төрийн архивын тасагт шилжүүлнэ/. гэж заасны дагуу 2023 оны 12 сарын 31-ний байдлаар тасалбар болгож холбогдох журмын дагуу төрийн архивт хүргүүлээр ажиллаж байна.


Тайлант хугацаанд шинээр үүсгэн байгуулагдсан хуулийн этгээдийн оноосон нэрийн баталгаажуулалт нийт 289 нэр олгосон байна. Үүнээс биечлэн ирсэн 213, цахимаар захиалж авсан 76 хүлээн авч шийдвэрлэсэн байна.

Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн портал e-business.mn-ээр ирүүлсэн нэр баталгаажуулах болон бүртгэл хийлгэх хүсэлт хүлээн авч шийдвэрлэсэн нийт **691** үүнээс зөвшөөрсөн 74, татгалзсан 525, баталсан 48 цахим гэрчилгээ 44 хүсэлтийг цаг хугацаанд нь түргэн шуурхай шийдвэрлэж ажилласан.

### ГУРАВ.АРХИВЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР


#### Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архив:

Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн архивт 2023 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн байдлаар нийт **19943** ширхэг хувийн хэрэг хадгалагдаж байна. Үүнээс:



2023 оны байдлаар нийт эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн анхны бүртгэл хийгдсэн шинэ хувийн хэрэг 769, үйлчилгээ хийгдсэн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн маягт, нотлох баримт 7841 ширхэгийг эд хөрөнгийн тасгийн дарга, улсын бүртгэгч нараас бүртгэлийн нотлох баримт, маягтыг архивт хүлээн авахдаа “Архивт хүлээлгэн өгөх бүртгэлийн дэвтэр”-ээр хүлээн авч нэг бүрчлэн хувийн хэрэгт нэгтгэн байршуулж хувийн хэргийн баяжилтыг хийж ажилласан байна.

Мэдээллийн санд хувийн хэргийн дугаарлалт, үйлчилгээний төрөл зөрүүтэй орсон архивын цаасан эх нотлох баримт үзэх шаардлагатай хувийн хэргийг



Эд хөрөнгийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах


бүртгэгч, Хяналтын улсын байцаагч, улсын бүртгэгч нараас “Архиваас хувийн хэрэг захиалах хуудас”-аар захиалга авч нийт 712 хувийн хэрэг гаргаж, буцаан хүлээн авч хувийн хэрэг гарсан болон хүлээн авсан он, сар, өдрийг бүртгэн захиалгын хуудсыг хаалт хийн хувийн хэргийг санд буцаан байршуулсан байна.

### Хуулийн этгээдийн бүртгэлийн архив:

Хуулийн этгээдийн бүртгэлийн архивт нийт 2795 ширхэг хувийн хэрэг хадгалагдаж байна.

Хуулийн этгээдийн улсын бүртгэгч Д.Отгонсүрэн Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2019 оны А/1050 дугаар тушаалын 2, 3 дугаар хавсралтаар батлагдсан "Хуулийн этгээдийн хувийн хэргийг архивт шилжүүлсэн жагсаалт"-аар "168 ширхэг шинэ хувийн хэрэг, "Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийн баримт бичгийг архивт шилжүүлсэн жагсаалт"-аар 258 ширхэг нотлох баримт материал хүлээн авч хувийн хэрэг тус бүрт нэгтгэн байршуулж, хувийн хэргийн баяжилт, хаягжуулалт хийж ажилласан байна.

Хуулийн этгээдийн улсын бүртгэгчээс 2023 онд бүртгэл хөтлөгдсөн нийт 232 баримтыг архивт хүлээн авч хадгаламжийн нэгж үүсгэн, тавиурт байршуулан ажилласан байна.



Хуулийн этгээдийн архивын сейф, шүүгээний эмх цэгцгүй байдлыг нэг бүрчлэн сайжруулан, эд хөрөнгө, хуулийн этгээдийн бүртгэлийн дэвтрийг он оноор нь төрөлжүүлээ.

Улсын бүртгэлийн ерөнхий газраас орон нутагт олгосон 5 сейфийг байгууллагын эрэгтэй ажилтнуудыг дайчлан Хуулийн этгээдийн архивт суурилуулан, тус архивт дараах материалуудыг байршуулан ажиллалаа.

1.Хуулийн этгээдийн архивын 2795 ширхэг хувийн хэргийг төрөлжүүлэн хаягжуулалт хийлээ.

2.Сумдын үл хөдлөхийн хувийн хэргүүдийг төрөлжүүлэн байршууллаа.

3.Шинээр баригдсан орон сууцны материалыг төрөлжүүлэн байрлуулах ажлыг хийж гүйцэтгэн баримт, бүртгэлийн төрөлжүүлэлт, эмх цэгц, хадгалалт хамгаалалт, аюулгүй байдлыг ханган ажиллалаа.

Улсын бүртгэлээс хасагдсан хуулийн этгээдийн 142 хувийн хэргийг архивын сангаас ялган, тусгай тавиурт хаягжуулалт хийн төрөлжүүлээ.

**Архивын хадгалалт хамгаалалт, аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд:**

Сумдын бүртгэгчээр шалгуулахад бүртгэлийн дугаар алдаатай, цахимжуулалт зөрүүтэй 500 хувийн хэргийг архивын сангаас ялгаж улсын ахлах бүртгэгч У.Золзаяатай өдөр өдөрт нь архиваас түр олгох хуудсаар гарган, хянуулан ажиллаж байна.

Аймгийн хэмжээний шинээр баригдсан 110 орон сууцны материалыг хянан шалгах цахимжуулах зорилгоор ахлах бүртгэгч У.Золзаяа, Улсын бүртгэгч А.Оюунсүвдад өдөр тутамдаа архиваас гарган хүлээлгэн өгч, хамтран ажиллаж байна.

Эд хөрөнгийн, архивын мэдээллийн самбарыг шинэчлэн цаг үеийн холбогдолтой мэдээ мэдээллийг байршуулан ард иргэдэд сурталчлан ажиллалаа.

Эд хөрөнгө, хуулийн этгээдийн архивын өрөөний гэрэлтүүлгийг стандартын дагуу болгох зорилгоор өөрийн дотоод нөөц бололцоогоо ашиглан шинэчлэх ажлыг зохион байгууллаа.

Газар, үл хөдлөх хөрөнгийн шинээр үүссэн хувийн хэрэгт хаягжуулалт хийж байршууллаа.

## **ДӨРӨВ. БҮРТГЭЛИЙН ХЯНАЛТ;**

### **4.1.Бүртгэлийн хяналт хийсэн талаар:**

**2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн байдлаар бүртгэлийн төрөл тус бүрд хяналт тавьсан байдал.**

Иргэний бүртгэлийн чиглэлээр 1020, Эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр 423, Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр 287, Архивын чиглэлээр 645, нийт 2375 бүртгэлд хяналт тавин ажиллалаа. **Хяналтын явцад** Иргэний бүртгэлийн 76, Эд хөрөнгийн чиглэлээр 11, Хуулийн этгээд 5, Улсын бүртгэлийн архивын /иргэний/ чиглэлээр 12, нийт 104 зөрчил илрүүлснийг тухай бүр залруулж ажиллав. 2023 онд төлөвлөгөөт шалгалт 1, гэнэтийн болон төлөвлөгөөт бус шалгалт 4 хийгдэж 1560бүртгэлд хяналт шалгат хийсэн байна. Өргөдөл, санал, гомдлын мөрөөр хийсэн шалгалт-443 байна.

**4.2 Зөрчлийн тухай хуулийн хэрэгжилт.** Зөрчлийн тухай хуульд заасны дагуу нийт 437 иргэний өргөдөл, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэв. Үүнээс 437

иргэнд шийтгэл ногдуулж, улсын төсөвт 8740000 төгрөгийн орлого төвлөрүүлээ. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэхдээ иргэн, хуулийн этгээдийн эрх, эрх чөлөөг хүндэтгэж, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчихгүй байхад анхаарч ажиллаж байна. Мөн зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг явуулахдаа хуульд заасны дагуу Прокурорын байнгын хяналтан дор хугацаанд нь хянуулан хамтран ажиллаж байна.

Зөрчлийн тухай хуулийн дагуу шийтгэл ногдуулсан иргэдийн бүртгэлийг бүртгэлийн төрлөөр нь ангилвал биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэл анх удаа бүртгүүлэх хугацаа хэтрүүлсэн /16 нас/-109, биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлд хуулийн хугацаанд бүртгүүлээгүй /25 нас/-175, биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлд хуулийн хугацаанд бүртгүүлээгүй /45 нас/-145, төрсний бүртгэлийн хугацаа хэтрүүлсэн -6, нас барсны бүртгэлийн хугацаа хэтрүүлсэн -2 зэрэг бүртгэлүүд байна.

Зөрчлийн тухай хуульд заасан зөрчил үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2023 онд 16, 25, 45 насанд хүрч буй өөрийн харьяалах сумын иргэдэд Багийн засаг дарга, нийгмийн ажилтантай хамтран утсаар холбогдож хуулийн хугацаандаа бүртгэл хийлгэхийг зөвлөж, мэдээллэж ажиллахыг сумдын улсын бүртгэгчдэд байнга зөвлөж ажиллаж байна. Мөн хэлтсийн хяналтын улсын байцаагчид өөрсдөө утсаар мэдэгдэн ажиллаж байна.

Зөрчлөөс урьдчилсан сэргийлэх ажлын төлөвлөгөөнд нийт 5 ажил тусгагдснаас 4 ажлыг хийж гүйцэтгэсэн 1 ажил нь хугацаа нь болоогүй хүлээгдэж байна.

1. Улсын бүртгэгч нарт “Зөрчлөөс урьдчилан сэргийлэх бүртгэлийн болон бусад холбогдох хууль тогтоомжийн талаар нэг мөр ойлголттой болох нь” сэдэвт 2 удаагийн танхимын сургалт хийж, нийт улсын бүртгэгч, УАБ нар оролцов.

2. Аймгийн төвөөс бусад 19 сумдын улсын бүртгэгч нарт үүрэг чилгэл өгч 2023 онд 16, 25, 45 нас болон төрөлт, нас баралт, гэрлэлт цуцлалт зэрэг хуульд заасан хугацаанд бүртгүүлэх бүртгэлүүдийг хугацаандаа бүртгүүлэх талаар 2 удаагийн онлайн сургалт хийж, 1 удаагийн танхимын сургалт хийсэн. Тус чиглэлийн дагуу сумдын улсын бүртгэгч нар сум, багийн FACEBOOK групп болон олон нийтийн бүхий л үйл ажиллагаанд улсын бүртгэлийн хууль тогтоомж болон Зөрчилд хуульд заасан зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдлэг, мэдээллийг байнга өгч ажиллаж байна.

3. Аймгийн Багийн Засаг дарга нартай хамтарч Улсын бүртгэлийн болон Зөрчлийн тухай хуульд заасан зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд: Аймгийн төвийн 1, 10 дугаар багийн Засаг дарга, нийгмийн

ажилтнуудтай хамтарт 2023 онд 16, 25, 45 нас болон төрөлт, нас баралт, гэрлэлт цуцлалт зэрэг хуульд заасан хугацаанд бүртгүүлэх бүртгэлүүдийг хугацаандаа бүртгүүлэх талаар иргэдэд мэдлэг, мэдээлэл хүргэж, 1, 10 дугаар багийн 450 иргэний судалгаа гаргаж, багийн нийт иргэдэд facebook группээр, 250 иргэнд утсаар мэдээлэл өгч хамтарч ажиллалаа.

4.Аймгийн Засаг даргын Тамгын хурлын танхимд 14 хоногт 1 удаа зохион байгуулагддаг Байгууллагын удирдлагуудын өглөөний хуралд /3 удаа/ оролцож, улсын бүртгэлийн хууль тогтоомжийн шинэчлэл, цаашдын зорилт болон бүртгэлтэй холбоотой Зөрчлийн тухай хуульд заасан зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдлэг, мэдээллийг хүргэж ажилласан зэрэг болно.

#### **4.3 Гурав. Хяналтын улсын байцаагчийн дүгнэлтийн талаар.**

Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн хамт олон бүртгэлийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, алдаа зөрчил гаргахгүй, улсын бүртгэлийг хууль зүйн дагуу үнэн зөв бүртгэл хөтлөх зорилтыг тавин ажиллаж байна.

2023 оны 11дүгээр сарын 20-ны өдрийн байдлаар Хяналтын улсын байцаагчийн нийт 123 дүгнэлт гаргаснаас иргэний бүртгэлийн чиглэлээр гарсан дүгнэлтүүдийг хүснэгтээр харуулвал. Үүнд:

<b>№</b>	<b>Дүгнэлтийн төрөл</b>	<b>Дүгнэлтийн тоо</b>
<b>1</b>	Бүртгэлд засвар, өөрчлөлт оруулах тухай	78
<b>2</b>	Бүртгэл хүчингүй болгох тухай	13
<b>3</b>	Регистрийн дугаар өөрчилж, дахин олгох тухай	1
	<b>Нийт</b>	<b>92ш</b>

Бүртгэлийн төрлөөр ангилвал.

<b>№</b>	<b>Дүгнэлтийн төрөл</b>	<b>Дүгнэлтийн тоо</b>
<b>1</b>	Иргэний бүртгэл	92
<b>2</b>	Хуулийн этгээдийн бүртгэлийн талаар	1
<b>3</b>	Эд хөрөнгө	30
	<b>Нийт</b>	<b>123ш</b>

#### **Хяналтын улсын байцаагчаас гарсан шийдвэрийг харуулбал:**

<b>№</b>	<b>Хяналтын улсын байцаагчийн</b>	<b>тоо</b>
<b>1</b>	Хяналтын улсын байцаагчийн дүгнэлт	123
<b>2</b>	Хяналтын улсын байцаагчийн шийтгэлийн хуудас	437



3	Хяналтын улсын байцаагийн мэдэгдэл	0
4	Хяналтын улсын байцаагчийн акт	0
5	Хяналтын улсын байцаагчийн албан шаардлага	0
	<b>Нийт</b>	<b>560ш</b>

#### 4.4. Бусад ажлын талаар

2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн байдлаар иргэн хуулийн этгээдээс ирүүлсэн нийт 110 өргөдөл, гомдол хүлээн авснаас 76 өргөдлийг хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр, 14 өргөдлийг улсын бүртгэгчид шилжүүлсэн, 7 өргөдлийг нотлох баримтын шаардлага хангаагүй, нотлох баримт нэмж бүрдүүлэх шаардлагатайн улмаас буцаасан /иргэнд/, 1 өргөдлийг амаар /утсаар хариу өгч/ хариу өгч шийдвэрлэсэн, 3 өргөдлийг УБЕГ-т албан бичгээр хүргүүлж шийдвэрлүүлсэн, Хяналтын улсын ахлах байцаагчийн 2023 оны 4865 дугаартай нэгдсэн дүгнэлтийн дагуу 6 өргөдлийг улсын бүртгэгчид шилжүүлж тус тус шийдвэрлэсэн.

Мөн хэлтсийн эрх бүхийн албан тушаалтны нийт 55 хүсэлтийг хүлээн авсан байна. Үүнээс эд хөрөнгийн бүртгэлтэй холбоотой 19 хүсэлт, Иргэний бүртгэлтэй холбоотой 35 хүсэлт, хуулийн этгээдийн бүртгэлтэй холбоотой 1 хүсэлтийг тус тус хяналтын улсын байцаагчийн дүгнэлт гарган шийдвэрлэсэн байна.

Иргэний улсын бүртгэлийн газраас 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд нэмэлт, өөрчлөлт хийх эрх олгогдсон байдаг. Үүний дагуу Хяналт шалгалтын газраас хяналт шалгалт хийгдсэний дагуу Баянхонгор аймгийн иргэний улсын бүртгэлийн нэмэлт өөрчлөлтийн 5 бүртгэлд зөрчил илэрснийг Хяналтын улсын байцаагчийн 2023 оны 05 дугаар сарын 11-ний өдөр 3260 дугаартай дүгнэлтээр зөрчлийг арилгав.

Мөн Хяналт шалгалтын газраас ирүүлсэн 2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 6/3684 тоот “Үүрэг, чиглэл хүргүүлэх тухай” чиглэлийн дагуу Баянхонгор аймгийн 20 суманд 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс 2023 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийг дуусталх хугацаанд бүртгэгдсэн нийт 497 шилжилт хөдөлгөөний бүртгэлд хэлтсийн дарга, хяналтын улсын байцаагчид хуваан хяналт шалгалт хийхэд нотцой зөрчил дутагдал илрээгүй байна. Нийт 23 бүртгэлд зөрчил илэрснээс мэдээллийн санд нотлох баримт дутуу цахимжсан-10, метадата шивэгдсэн боловч нотлох баримт харагдахгүй-1, илүү нотлох баримт цахимжуулсан-3, бүртгэлийн дэвтэрт засвартай –9 зэрэг байлаа.

2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн байдлаар бүртгэлийн хяналтын чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлын мэдээг Хяналт шалгалтын газарт 11 удаа хугацаандаа хүргүүлсэн [ch.erdenechimeg@burtgel.gov.mn](mailto:ch.erdenechimeg@burtgel.gov.mn), Аймгийн Прокурорын газарт зөрчлийн хэрэг бүртгэлттэй холбоотой хүлээн авсан өргөдөл, гомдлын мэдээг өдөр бүр [bayankhongor@prokuror.mn](mailto:bayankhongor@prokuror.mn) хаягаар илгээж, хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн зөрчлийн материалыг ажлын 5 өдөрт багтаан тухай бүр хүргүүлэн ажиллаж байна.

## **ТАВ. САНХҮҮ, ТӨСВИЙН УДИРДЛАГА, ТӨЛӨВЛӨЛТ БОЛОН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

Улсын бүртгэлийн хэлтэс нь 2023 оны 11 сарын 27-ны байдлаар улсын төсвөөс 850,496,3 мянган төгрөгийн урсгал санхүүжилт авч цалин хөлсний зардалд 624,792,9, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 128.446,3, гэрэл цахилгааны зардалд 2.389,8, түлш халаалтын 54.392,6, цэвэр бохир усны зардалд 1.904,1, бичиг хэргийн зардалд 10.504,0, тээвэр шатахууны зардалд 1.425,0, шуудан холбооны зардалд 1.240,8, хог хаягдал зайлуулах зардалд 500,0, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлсийн зардалд 1.870,0, багаж техник хэрэгслийн зардалд 1.464,0, хөдөлмөр хамгааллын хэрэглэлийн зардалд 180,0, урсгал засварын зардалд 1.654,9, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 3.170,1, мэдээллийн технологийн зардалд 4.000,0, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд 100,0, мянган төгрөг зарцуулж улсын төсвийн орлогын дансанд үндсэн үйл ажиллагааны орлого 172.841,2 мянган төгрөгийг улсын төсвийн дансанд төвлөрүүлэн ажиллаж байна.

УБЕГ-ын Санхүү, аж ахуйн хэлтэсээс 7.306,7 мянган төгрөгийн үнэт цаас, хангамжийн материал, 4.547,9 төгрөгийн бэлэн бүтээгдэхүүн хүлээн авч, төсвийн хөрөнгөөр 20.897,9 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан байна. Бараа материалын данснаас 22.530,1 мянган төгрөгийн үнэт цаас, хангамж, бусад бараа материалд хөдлөл өөрчлөлтөөр бүртгэн сар бүр үнэт цаасны тайлан няравын тайланг гаргуулан авч Санхүү, аж ахуйн хэлтэст хүргүүлж хэвшсэн.

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж сар, улирал, хагас жилийн тайланг УБЕГ-ын Санхүү, аж ахуйн хэлтэст 10 удаа, Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэст сар бүр, Татварын хэлтэст улирал бүртайлан мэдээг хуулийн хугацаанд гарган баталгаажуулан харилцагч байгууллагуутдай тооцоо нийлж өглөг авлага үүсгэхүй байх тал дээр анхааран ажиллаж байна.

Байгууллагын 2024 оны төсвийн төсөл, 2025-2026 оны төсвийн төсөөллийг хуулийн хугацаанд гарган УБЕГ-т хүргүүлсэн. Мөн Хууль зүй, дотоод хэргийн яамны opendata системд байршуулсан.

Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын тогтоолын дагуу байгууллагын санхүүгийн мэдээллийг [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn), сайтад сар бүр тогтмол байршуулан 129 удаагийн мэдээлэл шинэчилж, [www.bayankhongorburtgel.com](http://www.bayankhongorburtgel.com) сайтад тогтмол байршуулан 11 удаагийн мэдээлэл шинэчилж ажилласан.

2022 оны Санхүүгийн тайлан, санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Төрийн Аудитын байгуулагаар шалгагдаж “Зөрчилгүй” санал дүгнэлтэй ажиллаж, аудитаар өгсөн 1 зөвлөмжийн биелэлтийг заасан хугацаанд Төрийн аудитын байгууллага болон УБЕГ-ын БТДШГазарт хүргүүлсэн.

2023 оны 11 дүгээр сарын 27-ний байдлаар батлагдсан төсөв хүрэхгүйгээс шалтгаалан гэрэл цахилгааны зардалд 10.513,4, гэрэл цахилгааны зардалд 157,9,цэвэр бохир усны зардалд 305,3, тээвэр шатахууны зардалд 1.022,1, хог хаягдлын зардалд50,0, нийт 12.048,8мянган төгрөгийн өглөгтэй байна.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас 2022 оны байгууллагын “Өмч эзэмшлийн гэрээ”-ний биелэлтийн дүнгээр Сайн үнэлгээ авч “Өргөмжлөл”-өөр шагнагдсан байна.

## **ЗУРГАА.БАЙГУУЛЛАГЫН ДОТООД АЖИЛ, ҮЙЛ АЖИЛЛАГААГ СУРТАЛЧЛАХ АЖИЛЛАГАА**

### **6.1.Байгууллагын архив, бичиг хэргийн эргэлтийн бүртгэл, тайлан**

Хэлтсийн хэмжээнд 2023 оны 11 дүгээр сарын 27-ны байдлаар ирсэн албан бичиг 728, Улсын Бүртгэлийн Ерөнхий газрын даргын тушаал, чиглэл, зөвлөмж , дотоод албан бичиг нийт 77 тус тус бүртгэгдсэн байх ба хэлтсээс 830 албан бичиг явуулсан байна.

Ирсэн, явсан албан бичиг болон өргөдөл, гомдлыг скайнердэж **Able, edoc** программ дээр бүртгэн хяналтын карт хөтлөн хяналт тавин ажиллаж байна.

Хэлтэст нийт 416 **хариутай албан бичиг ирүүлсэн ба** хуулийн хугацаа хэтрүүлэн хариу илгээсэн албан бичиг байхгүй болно.

Удирдлагаас гарах шийдвэрийн болоод зохион байгуулалтын баримт бичиг буюу Хэлтсийн даргын тушаал 22, хамт олны хурлын тэмдэглэл 4 гарсан байна.

### **6.2 Иргэдээс ирсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлт**

Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу байгууллагад ирсэн өргөдлийг бүртгэлжүүлэн хариуг хуулийн хугацаанд шийдвэрлэн ажиллаж байна. 2023 оны 11дүгээр сарын 27-ны өдрийн нийт 182өргөдөл ирсэн

. Үүнээс бүрэн шийдвэрлэсэн 157, шийдвэрлэх шатандаа 25 байна. Өргөдөл гомдлын мэдээг улирал тутам аймгийн Төрийн захиргаа удирдлагын хэлтэст, Ерөнхий газрын өргөдөл гомдол хариуцсан мэргэжилтэнд тус тус хүргүүлэн ажиллаж байна.

### **6.3 Үйл ажиллагааг сурталчилсан байдал**

УБЕГ-аас нэгдсэн байдлаар үүсгэн хөтлөж буй хэлтсийн вэйб хуудсанд хэлтсээс хийж хэрэгжүүлж буй ажил үйлчилгээ, зохион байгуулсан сургалт, цаашид хийж хэрэгжүүлэх ажлууд, бүртгэлийн тоон мэдээ, нээлттэй ажлын байрны зар гээд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан байгууллагат хамаарах бүх төрлийн мэдээ мэдээллийг тухай бүр нь байршуулж иргэд олон нийтэд түгээн дэлгэрүүлэн ажиллаж байна. /Bayankhongor.burtgel.gov.mn/ Тус хаягт сүүлийн хагас хагас жилийн байдлаар 55 үйл ажиллагааг сурталчлан байршуулсан байна. Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс гэсэн фэйсбүүк пэйж хуудсанд 285 удаагийн мэдээ мэдээллийг тавьж байршуулан иргэд олон нийтэд сурталчилж хамгийн олон хандалт авсан мэдээ мэдээлэл нь оны хөдөлмөрийн аваргаар шалгарсан мэдээлэл, хэлтсээс олон нийтийн ажилд оролцсон тухай болон Нээлттэй хаалганы өдрийн мэдээ мэдээллүүд байна.

Хэлтсийн албан хаагчдад УБЕГ болон хэлтсээс зохион байгуулсан ажил үйлчилгээ, орон нутгийн төр захиргааны байгууллагын бодлого шийдвэрийг сурталчлахад идэвхтэй оролцон холбогдох цахим хаягуудад хандалт хийж уншиж танилцаж, шэйр хийн хууль тогтоомжийг сурталчлан таниулах үүргээ гүйцэтгэж идэвхтэй ажиллах үүргийг өгч гүйцэтгэлийн төлөвлөгөөнд арга хэмжээ болгон тусган хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж хэвшсэн.

Байгууллагын үйл ажиллагааг сурталчилж буй бас нэг хэлбэр бол “Нээлттэй хаалганы өдөрлөг” зохион байгуулах ажил бөгөөд **“Нээлттэй хаалганы өдөрлөг”**-ийг дараах байдлаар зохион байгуулж ажиллалаа. Мөн энэ үеэр Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан **“Сумдад эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх ажлыг үргэлжлүүлэх, нэмэгдүүлэх”** ажлын хүрээнд 2023 оны жилийн эцсийн байдлаар 2023 онд **Хүрээмэрэл, Баянбулаг, Бууцагаан, Баянцагаан, Бөмбөгөрсумдад** газар дээр нь очиж үйлчилгээ үзүүлсэн. Үүнд:

1.“Нээлттэй хаалганы өдөр” арга хэмжээг Баянхонгор сумын Шаргалжуут 8 дугаар багт зохион байгуулж Улсын бүртгэгч Г.Бадамханд 146, Б.Өлзийбаяр 411 бүртгэл хийсэн.

2. **Хүрээмарал** сумд 2023 оны 05 сарын 26-27-ны хооронд зохион байгуулж тус арга хэмжээний хүрээнд Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээ 2 иргэн авсан бол эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 3 иргэнд холбогдох зөвлөгөө өгч, Тоон гарын үсэг-322, иргэний үнэмлэх шинээр авсан-1, 25,45 насны сунгалт-7, иргэний үнэмлэх олголт-6, иргэний үнэмлэх дахин авсан-2, гадаад паспорт-21, нийт 361 бүртгэл тус тус бүртгэсэн.



3. Улсын бүртгэлийн хэлтсээс 2023 оны 10 дугаар сарын 26-28-ны өдрүүдэд "Нээлттэй өдөрлөг" арга хэмжээг удирдамжийн дагуу Хүрээмарал, Баянбулаг,


### НЭЭЛТТЭЙ ХААЛГА -ны өдөрлөг

УЛСЫН БҮРТГЭЛИЙН БАЙГУУЛЛАГА ҮҮСЭЖ ХӨГЖСӨНИЙ 83 ЖИЛ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН АЖИЛТНЫ ӨДРИЙГ УГТАН СУМД БҮРТГЭЛИЙН ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ЗОРИЛГООР ДАРААХ СУМДАД "НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨР"-ИЙГ ЗОХИОН БАЙГУУЛЖ БАЙНА.

БУУЦАГААН СУМ	2023-10-26
ХҮРЭЭМАРАЛ СУМ	2023-10-27,28
БАЯНБУЛАГ СУМ	2023-10-27,28

ТА БҮХЭН СУМАНДАА ДАРААХ ЧИГЛЭЛЭЭР БҮРТГЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ АВЧ ҮЙЛЧЛҮҮЛНЭ ҮҮ

- ИРГЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:
- ЭД ХӨРӨНГИЙН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:
- ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:
- ТООН ГАРЫН ҮСЭГ ОЛГОЛТ
- ГАДААД ПАСПОРТЫН БҮРТГЭЛ



### БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС

Бууцагаан, Баянцагаан сумдад амжилттай зохион байгуулж явууллаа. Тус өдрүүдэд Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр Тоон гарын үсгийн бүртгэл 305, Гадаад паспортын бүртгэл 126, лавлагаа 3 олгосон бол Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 62 бүртгэл хөтөлж 104 зөвлөгөө, Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр 3 бүртгэл хөтөлж, зөвлөгөө 29 тус тус өгч ажиллалаа.

## ДОЛОО. БАЙГУУЛЛАГЫН АЛБАН ХААГЧДЫН СУРГАЛТ, ХӨГЖИЛ, ЁС ЗҮЙ

### 7.1. Албан хаагчдын сургалт, хөгжил

Байгууллагын нийт албан хаагчдыг чадавхжуулах, мэдлэг чадварыг дээшлүүлэх, төрийн албан хаагчийн хөрвөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор хэлтэс нь сургалт, сурталчилгааны ажлын төлөвлөгөөг хагас бүтэн жилээр батлан хэрэгжүүлж хэвшсэн бөгөөдэхний хагас жилийн байдлаар хэлтсийн дотоод сургалт нийт 18 удаагийн сургалт мэдээллийн цаг орохоор төлөвлөснөөс 2 сургалт Насан туршийн боловсролын төвөөс шалтгаалан тасарсан. Хэлтсийн албан хаагчдын нэгдсэн сургалтыг мөн тусгай хөтөлбөр гарган хэрэгжүүлж 3 дугаар сарын 30-31-ний өдөр зохион байгуулж ирц 97,2 хувьтай оролцлоо. Сургалтуудаас дурьдвал:

Тус хэлтсээс аймгийн Насан туршийн боловсролын төвтэй 2 дахь жилдээ хамтран ажиллаж байна. Байгууллагын 2023 оны сургалтын төлөвлөгөөнд туссан дагуу анхны сургалтыг "Ёс суртахууны төлөвшил" сэдвээр тус төвийн сургагч багш Мөнхнасан зохион байгуулж явууллаа.

УБЕГ-т 2023 оны 03 дугаар сарын 17-18-ны өдрүүдэд зохион байгуулагдсан Удирдах ажилтны нэгдсэн сургалт семинарийн дараагаар хэлтсийн нийт албан хаагчдын нэгдсэн сургалт зөвлөлгөөнийг 2023 оны 3 дугаар сарын 30-31-ний өдөр тусгай хөтөлбөрийн дагуу зохион байгуулж явуулав.



Сургалтын хөтөлбөрийн дагуу Улсын бүртгэлийн байгууллагын шинэтгэлийн үйл явц, Архив албан хэрэг хөтлөлтийн эрх зүйн шинэчлэл, Нийтийн мэдээллийн ил тод байдал ба холбогдох хууль тогтоомжид орсон өөрчлөлт, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх асуудал, Жендэрт суурилсан гэр бүлийн хүчирхийлэл зэрэг 12 сэдвээр албан хаагчдад 2 өдрийн турш хэлтсийн дарга, ахлах бүртгэгч, хяналтын улсын байцаагчид болон холбогдох бусад байгууллагын албан хаагчид сургалт мэдээлэл хийлээ. Мөн энэ үеэр хэлтсийн хяналтын улсын байцаагч Л.Мэндбаярыг Хууль зүй, дотоод хэргийн яамны "Жуух бичиг" -ээр, Жинст сумын улсын бүртгэгч Б.Тунгалаг, ахлах нягтлан бодогч Г.Бат-Очир нарыг "Улсын бүртгэлийн Тэргүүний ажилтан" цол тэмдгээр шагнасныг тус тус гардуулан өгч, хамт олноос нь эрүүл энх хамгийн сайн сайхныг хүсэн ерөөлөө.

Монгол орон даяар жил бүрийн 4 дүгээр сард тэмдэглэн өнгөрүүлдэг "Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй" аяны хүрээнд 2023 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр тус хэлтсээс Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйчилгээний газарт хүсэлт тавьж нийт албан хаагчдад дээрх сэдвийн хүрээнд, мөн аймгийн



Насан туршийн боловсролын төвөөс "Хуримтлал ба хадгаламж" сэдвээр тус тус сургалт зохион байгууллаа. Сургалтанд хэлтсийн төвийн албан хаагчид танхимаар, сумдын албан хаагчид онлайнаар оролцлоо.

Улсын бүртгэлийн хэлтсээс Байгууллагын 2023 оны сургалтын төлөвлөгөөнд туссан дагуу аймгийн Насан туршийн боловсролын төвтэй хамтран "Гэр бүлийн эрүүл мэнд" сэдэвт сургалтыг 03 дугаар сарын 01-ний өдөр зохион байгуулав. Сургалтанд хэлтсийн төвийн албан хаагчид танхимаар, сумдын албан хаагчид онлайнаар хамрагдлаа.



Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар зохион байгуулж буй "Эрүүл



монгол хүн" үндэсний хөдөлгөөн, "Энэ жилдээ -эрүүл жиндээ", "Цаг гаргая" аянд нэгдэж хэлтсийн хамт олон 5 сарын 17-ны өдөр 07.00 цагт Аймгийн Биеийн тамир спортын газарт зохион байгуулагдаж буй дасгал хөдөлгөөнд оролцсоны дараагаар, ажлын байрны сургалтын танхимд 08.00 цагт аймгийн Эрүүл мэндийн газрын мэргэжилтнүүд "Илүүдэл жин ба дасгал хөдөлгөөн", "Зохистой хоололт ба эрүүл мэнд" гэсэн сэдвээр сургалт зохион байгууллаа.

Сүүлийн хагас жилийн сургалтын төлөвлөгөөг 13 сургалт зохион байгуулахаар төлөвлөн хэрэгжүүлснээс дурдвал:

ХЭҮК-оос зарласан "Ажлын байр-Бэлгийн дарамтгүй орчин" аянд аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн хамт олон нэгдэж "Ажлын байрны бэлгийн дарамт, хөдөлмөрийн хүрээний дарамт хүчирхийлэл" сэдвээр Хүний эрхийн комиссын аймаг дахь референт Б.Содонцэцэгээс ээлжит сургалтаа авч хүний эрхийн талаарх мэдлэг ойлголтоо дээшлүүллээ. /2023.10.11 /

Хэлтсийн ээлжит сургалтыг 2023 оны 10 дугаар сарын 18-ны өдөр хэлтсийн төвийн албан хаагчдад танхимаар сумдын албан хаагчдад онлайнаар зохион байгуулав. Энэ удаагийн сургалтыг хэлтсийн дарга Ц.Мөнхжаргал **"Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулиар**, аймгийн Цагдаагийн газрын сэтгэл зүйч цагдаагийн ахмад Д.Хоролгаравыг урьж **"Стрессгүй ажлын байр ба хамт олны уур амьсгал"** сэдвээр тус тус зохион байгуулж явууллаа.

Улсын бүртгэлийн хэлтсийн хамт олон Лхагва гараг бүрийн 08.00 цагт хийж хэвшсэн сургалтын цагаараа 2023 оны 10 дугаар сарын 25-ны өдөр "Ард түмэнд үйлчлэх зарчим ба ашиг сонирхолын зөрчил" сэдвээр Аймгийн ЗДТГ-ын ХЭЗХ-ийн мэргэжилтэн Ж.Лхамдулам, "Хандлага" сэдвээр улсын бүртгэгч Г.Бадамханд /гүйцэтгэлийн төлөвлөгөөний мэдлэг чадвар хэсэг дэх арга хэмжээ / нараар сургалт мэдээлэл хийлгэлээ.Тус сургалтанд танхимаар 16,онлайнаар 11 албан хаагч хамрагдлаа.



Улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагааны эрсдэлийг бууруулах ажлын ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, улсын /ахлах/ бүртгэгч нарт бүртгэл хөтлөхөд гарч болзошгүй эрсдэлийг бууруулах мэргэжил арга зүйгээр хангах, тулгарч буй асуудлаар нэгдсэн ойлголт, зөвлөмж чиглэл өгөх сургалтыг 2023 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр зохион байгуулж илтгэх хуудсыг [otgontuya@burtgel.gov.mn](mailto:otgontuya@burtgel.gov.mn) хаягаар илтгэх хуудсыг хугацаанд нь хүргүүлэв. Сургалтад хэлтсийн төвийн албан хаагчид танхимаар, сумдын улсын бүртгэгч нар цахимаар оролцов.



Дараагийн сургалтыг Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам” шинэчлэгдэн батлагдсантай холбогдуулан хэлтсийн дарга 2023 оны 11 дүгээр сарын 8-ний өдрийн 08.00 цагт тус журмаар сургалт мэдээллийг хийлээ.

Монгол улсын хууль тогтоомж, бодлогын бичиг баримтыг хэрэгжүүлж ажиллах үүргийг байгууллага хүлээдэг ба энэ хүрээнд тус хэлтсээс "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр- III"-ийг хэрэгжүүлэх зорилгоор "Бүртгэлийн ажилтны өдөр"-ийг тохиолдуулан Монгол бичгийн танхимын сургалтыг 2 дахь удаагаа 2023 оны 11 дүгээр сарын 09-ний өдрөөс эхлүүлж 11 дэх өдрөө хичээллэж байгаа ба 11 дүгээр сарын 22-25-ны өдрийн хооронд "Хос бичигтэн" уралдаанд хамт олноороо оролцлоо.

Энэхүү уралдаанд бэлтгэж ажилтнууддаа Ү.Ариунболд багшийн эрхлэн гаргасан “Тод мөр” номыг Улаанбаатар хотоос нэг бүрийг нь 8000 төгрөгөөр нийт 15 номыг захиалан худалдан авч уншиж бичих дадлагатаа ашиглаж байна. Олимпиадын удирдамжийн дагуу албан хаагчдыг бэлтгэж шалгарсан нэг албан хаагчийн оролцуулахаар багштай тусгайлан бэлтгэсний дагуу 2023 оны 11 сарын 25-ны өдөр нийт 23 байгууллагын албан хаагчидтай өрсөлдөж эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч А.Оюунсүвд 9 дүгээр байрт шалгарлаа.

#### **УБЕГ болон бусад байгууллагаас зохион байгуулсан сургалтууд:**

Хэлтсийн албан хаагчдад мэдлэг мэдээлэл өгч, чадавхжуулсан бас нэг сургалт бол Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулж хэвшсэн 7:4:10 сургалт сургалт бөгөөд нийт зохион байгуулагдсан сургалтуудад хамт олон бүрэн хамрагдлаа. УБЕГ-аас болон бусад байгууллагатай хамтран зохион байгуулсан сургалтанд онлайнаар 18 удаа, АЗДТГ-аас зохион байгуулсан сургалтанд танхимаар 10 удаа тус тус хамрагдсан байна.

Нийт албан хаагчдын оролцоог хэлтсийн дарга биечлэн бүртгэж идэвх оролцоог ажлын гүйцэтгэлийг үнэлэхэд мэдлэг чадвар хэсэгт харгалзан үздэг болно.

Шинэ сэргэлтийн бодлого хөтөлбөрийн хүрээнд бүх албан хаагчид суралцсан ба танхимаар 15, цахимаар 30 албан хаагч суралцаж шалгалтаа өгч сертификатаа гардан авсан байна.

Эрүүл монгол хүн үндэсний хөтөлбөрийн хүрээнд Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвөөс "Эрүүл зөв амьдралын дадал зуршил" сэдэвт сургалтыг хэлтсийн албан хаагчдад зохион байгууллаа.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 05-р зарлигаар батлагдсан “Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах журам”-ын хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын алба, Стратеги судалгааны хүрээлэнгээс ҮАБЗ-ийн ахлах референт Д.Пандиймаа тэргүүтэй ажлын хэсэг манай аймагт ажиллаж үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон асуудлын хүрээнд тодорхой сэдвүүдээр сургалт мэдээллийг тус тус өгсөн.

Тодруулбал, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдал ба эрх зүйн орчин, ҮАБ-ын гадаад орчин: Дэлхий дахин ба гадаад бодлого, ҮАБ-ын дотоод орчин: Орон нутаг ба эрсдэл, Мэдээллээр хангах журмын хэрэгжилт анхаарах асуудал сэдвээр Төрийн захиргаа, төрийн цэргийн болон хууль сахиулах, төрийн үйлчилгээний байгууллагын удирдлага, холбогдох мэргэжилтнүүд сургалт авсанд хэлтсийн дарга, иргэний улсын ахлах бүртгэгч нар хамрагдсан

## **9.2. Албан хаагчийн ёс зүйн асуудал**

Улсын бүртгэлийн байгууллага нь төрийн үйлчилгээний 70 гаруй хувийг үзүүлдэг, мөн өдөр тутамдаа байнгын ачаалалтай ажилдаг зэрэг ажлын онцлогоос шалтгаалан харилцааны ур чадварыг цаг ямагт шаардаж байдаг ба хамгийн гол нь харилцаа хандлага л чухал түүнд анхаарч түүнийг эрхэмлэн ажиллахыг зөвлөн ажиллаж байна.

Иргэдийн сэтгэл ханамжийн байдлыг тандах, албан хаагчдын харилцаа хандлагыг өөрчлөх, байгууллагын үйлчилгээг сайжруулах, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах, үйлчилгээний стандартыг мөрдүүлэх зорилгоор үйлчилгээний зааланд санал хүсэлтийн дэвтэр, өргөдөл гомдол хүлээн авах 70440517 дугаарын утсыг тогтмол ажиллуулж байна.

2023 он гарсаар өнөөдрийг хүртэл ёс зүйн зөрчил гаргасан талаар ямар нэгэн өргөдөл гомдол ирүүлээгүй байна.

### **НАЙМ. ОРОН НУТАГ ДАХЬ ХАМТЫН АЖИЛЛАГАА**

Аливаа байгууллага орон нутгийн удирдах байгууллага, түүний хамт олонтой нягт хамтран ажиллах нь төрийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, байгууллага чиг үүргээ амжилттай хэрэгжүүлэх бас нэгэн тулгуур билээ. 2023 он гарсаар хэлтсээс орон нутагтай дараах байдлаар хамтарч ажиллалаа.

1.Баянхонгор сумын Засаг даргын захирамжийн дагуу сар бүрийн 12-ны өдөр хуваарьт газартаа бүх нийтийн цэвэрлэгээ хийхээр тогтоосон дагуу хэлтсийн албан хаагчид аймгаас баруун тийш зорчих хот хоорондын замын хоёр талаарх хог хаягдлыг 10 удаа цэвэрлэж дахивар хог хаягдлыг тушаах цэгт нь хүргэж өгч

ажиллалаа.



2. Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, ой, усны нөөцийг хамгаалж, нэмэгдүүлэх, экологийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг санаачлан өрнүүлсэнд нэгдэж тус хэлтэс нь Баянхонгор сумын Засаг даргын А/95 дугаар захирамжийн дагуу Бүх нийтээр мод тарих өдрийг тохиолдуулан 2023 оны 05 дугаар сарын 19-ний өдөр Шинэ суурьшлын бүсийн хуваарьт газраа 50 ширхэг, 10 дугаар сарын 31-ны өдөр 60 ширхэг “Улиас” нэмж тарьлаа. Мөн хэлтсийн гаднах хог цэвэрлэгээг тогтмол хийж, цэцгийн мандалд



цэцгийн үрээ суулгалаа.

3. Аймгийн Төрийн албаны салбар зөвлөлөөс 3,5, 9,11 дүгээр саруудад зохион байгуулсан төрийн албан хаагчийн шалгалтын комисст ажиллан, шалгалтанд оролцогчдын мэдээллийг хурууны хээгээр шалган оруулж хамтран ажиллалаа.

4. Аймгийн ЗДТГ-аас 14 хоногт нэг тутмын Мягмар гарагт зохион байгуулагддаг шуурхайд хэлтсийн дарга бүрэн хамрагдаж албан хаагчдад мэдээ мэдээллийг түргэн шуурхай хүргэн ажиллав.

5. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж буй “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөн “Цаг гаргая” аянд нэгдэж 2023 оны 04 сарын 28-ны өдөр хэлтсийн хамт олон 07.00-08.30 цагт дасгал хөдөлгөөн хийсэн бол Хүн бүр



[#Дасгал](#) Хөдөлгөөнд-Цаг Гаргая

[#Алхалтад](#)-Цаг Гаргая

[#Дугуй](#) Унахад-Цаг Гаргая

уриатайгаар хэлтсийн хамт олон 5 сарын 13-ны өдөр Нарны алхалтад оролцож дасгал хөдөлгөөн хийлээ.



6. Баянхонгор аймгийн Гэмт хэргээс

урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 2023 оны төлөвлөгөөнд тусгагдсан ажлын хүрээнд аймгийн Прокурорын газартай хамтран 2023.05.04-ний өдөр “Баянхонгор аймгийн хуулийн байгууллагуудын зөвлөгөөн”-ийг зохион байгуулсан бөгөөд үүнд



хууль сахиулах, хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллагын болон манай хэлтсийн хяналтын улсын байцаагч нарын 31 байгууллагын 130 алба хаагч хамрагдав.

7. Засаг захиргааны анхан шатны нэгжид ажилладаг Багийн Засаг дарга нарт Монгол Улсын хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийг танилцуулах, багийн иргэдэд чиглэсэн төрийн үйлчилгээг чанаржуулж, харилцан хамтран ажиллах агуулгын хүрээнд аймгийн ЗДТГ-аас 2023 оны 04 дүгээр сарын 14 -ний өдөр 20 сумын Засаг даргын орлогч, 105 багийн дарга нарын дунд нэгдсэн сургалт, семинарыг зохион байгуулсан ба хэлтсээс Улсын бүртгэлийн байгууллагаас 2022 онд хийж хэрэгжүүлсэн ажил, ололт амжилт, 2023 онд хийгдэх ажлуудын талаарх товч мэдээллийг хийж Тоон гарын үсэг олголтын ажилд сум, багуудыг идэвх санаачилгатай хамтран ажиллахыг уриаллаа.



8. Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Онцгой байдлын ерөнхий газартай хамтран төрийн болон төрийн бус байгууллагуудын уялдаа холбоо, бэлтгэл бэлэн байдлыг дээшлүүлэх "Стратегийн команд штаб"-ын дадлага, сургуулийг 06 сарын 07-09-ний өдрүүдэд зохион байгуулж байна. 6 дугаар сарын 08-ны өдрийн 16 цагт гамшгийн аюулын зарлан мэдээллэх дохиогоор ажлын байрандаа дадлага, сургуулилт хийлээ.



9.Баянхонгор аймагт 2023 оны 6 дугаар сарын 19-29-ний өдөр зохион байгуулагдсан“Хүүхдийн спортын их наадам”-д хамтран зохион байгуулагч



байгууллагаар оролцож илтгэх хуудсыг Аймгийн Биеийн тамир спортын газарт хүргүүлэв.

10. Баянхонгор сумын ЗДТГ болон аймгийн ЗДТГ-ын Хууль,эрх зүйн хэлтсээс хамтран 2023 оны 10 сарын 04-ний өдөр зохион байгуулсан нэгдсэн сургалтанд хамрагдсан Баянхонгор сумд бүртгэлтэй Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч 80 орчим иргэн, аж ахуйн нэгжүүдийн төлөөлөлд Хуулийн этгээд байгуулах, хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгүүлэхэд анхаарах асуудал, Иргэний болон хуулийн этгээдийн тоон гарын үсэг, түүний хэрэглээний талаар сургалт хийж, 26 иргэнд Тоон гарын үсэг олголоо.1.Тус хэлтэс нь "Төрийн цахим үйлчилгээг олон нийтэд сурталчлан таниулах" ажлын хүрээнд Цахим хөгжил, харилцаа холбооны яамны хэрэгжүүлэгч агентлаг төрийн Цахим үйлчилгээний Зохицуулалтын газрын Баянхонгор аймаг



дахь Төрийн Цахим үйлчилгээний хэлтэстэй хамтран 2023 оны 10 дугаар сарын 10-наас 11 дүгээр сарын 06-ны өдрүүдэд төрийн албан хаагчдад цахим ур чадварын мэдлэг олгох болон Тоон гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлэхэд чиглэсэн сургалт зохион байгуулахаар төлөвлөсний дагуу аймгийн Онцгой байдлын газар, Нийтийн номын сан, Тэмүүжин театр, Музей гээд төрийн болон төрийн өмчид байгууллага, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, орон нутагт үйл ажиллагаа явуулж буй томоохон аж ахуйн нэгж байгууллагын ажилтан, албан хаагчид хамрагдсан бол 11 сарын 06-ны өдрийн ээлжилт сургалтанд аймгийн "Баянхонгор-Эрчим хүч" Компанийн ажилтан, албан хаагчид хамрагдлаа. Уг сургалтын үр дүнд иргэдийн цахим ур чадвар дээшилж, Тоон гарын үсгийн хэрэглээ нэмэгдэж, улмаар цахим орчин дахь мэдээллийн аюулгүй байдлаа хамгаалах арга барилыг эзэмших юм.

12. Хэлний бодлогын Баянхонгор сумын салбар зөвлөлөөс Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны "Эх хэлний өдөр зарлах тухай" 25 дугаар зарлиг, Баянхонгор сумын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.7 дахь заалтыг тус тус хэрэгжүүлэх, эх хэлээрээ бахархах, сурталчлан таниулах, эх хэлний зохистой хэрэглээ бий болгох, Монгол өв соёлоороо бахархан, түгээн дэлгэрүүлэх зорилгоор зохион байгуулсан төрийн албан хаагчдын "Үсэглэлийн аварга" үг үсэглэх багийн тэмцээн, Ерөнхий боловсролын сургуулийн багш, сурагчдын "Эх хэл, үндэсний бичгийн бүтээлийн үзэсгэлэн" зохион байгууллаа. Үг үсэглэх тэмцээнд 16 байгууллага мэдүүлгээ өгч оролцсоноос тус хэлтсийн хамт олон 3 байранд шалгарч "Өргөмжлөл" мөнгөн шагналаар шагнагдлаа.




## ЕС.ХЭЛТСЭЭС ЗОХИОН БАЙГУУЛСАН БУСАД АЖИЛ

Албан хаагчдынхаа чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, холбогдох төлөвлөгөөний биелэлтийг хангах чиглэлээр 3 дугаар сарын 30-31-ний өдрүүдэд “Идэвхтэй хөдөлгөөн эрүүл амьдралын үндэс” аяны хүрээнд спортын 3 төрөлт тэмцээнийг зохион байгуулж явууллаа. Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, Монгол цэргийн баярыг тохиолдуулан хамтатган албан хаагчдын дунд Монета зарлаж бэлэг солилцдог уламжлалаараа энэ өдөр мөн бэлгээ солилцож бие биендээ урмын сайхан халуун дулаан үгээ хэлж, хамтдаа өнгөрүүлсэн дурсамжит нэгэн өдөр нэгээр нэмэгдсэн юм.



Үндэсний энгийн болон цахим гадаад паспортын загварууд шинэчлэгдэн хэвлэх үйлдвэр УБЕГ-т ажиллаж эхлэсэнтэй холбоотойгоор улс орон даяр шинэ паспортуудыг нэгэн зэрэг олгох ажлыг эхлүүлэх ажлын аймгийн хэмжээнд зохион байгуулж орон нутгийн ТВ-д мэдээлэл өгч олон нийтэд түгээх дэлгэрүүлэх ажлыг хийсэн.



Хэлтсийн “Эцэг эхийн зөвлөл”-өөс санаачлан “Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг тохиолдуулан Улс орныхоо ирээдүй болсон хойч үе, үр хүүхдүүдтэйгээ хагас өдрийг дурсамж дүүрэн өнгөрүүлж , бэлэг гардуулав.





- Хэлтсээс сайн үйлсийн аянд нэгдэж Баянхонгор сумын иргэн Б.Ууганбаатарт сэтгэлийн хандиваа өргөн хурдан эдгээрэй гээд 320000 төгрөгийг хандивлав.

2023 оны 06 дугаар сарын 16-ны өдөр тус аймгийн Богд сумын нутаг байрлах “Оюу Номин нуур”-ын явган аяллыг зохион байгуулав.



УБЕГ-аас баталсан Удирдамжийн дагуу 2023 оны 11 дүгээр сарын 16-19-ний өдрүүдэд Улаанбаатар хотноо Хангайн бүсийн аймгуудын ажилтнуудаас бүрдсэн бага тамирчдын хамтаар Спортын арга хэмжээнд оролцов.



## “ТӨРИЙН БҮТЭЭМЖ БА ҮНЭЛГЭЭ, МОНИТОРИНГ” СУРГАЛТЫНТАЛААР:

Баянхонгор аймгийн бодлогын баримт бичиг хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааны үр дүнг нэмэгдүүлэх, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, байгууллага хоорондын уялдаа холбоог сайжруулах зорилгоор 2023.10.27-ны өдөр АЗДТГ-ын Хяналт шинжилгээ,



үнэлгээний хэлтсээс аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 23 агентлаг, Төрийн болон орон нутгийн өмчит 10 байгууллагын удирдлага, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт хариуцсан мэргэжилтний дунд зохион байгуулсан бөгөөд уг сургалтанд Хэлтсийн дарга Ц.Мөнхжаргал “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийг хэрэгжүүлэх нь” сэдвээр мэдээлэл хийж, үдээш хойш нь сургалтад хамрагдагсад хууль тогтоомж, тогтоол шийдвэр бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг үр дүнтэй зохион байгуулж буй ХХААГ, СХДАА, МЭГ, **Улсын бүртгэлийн хэлтсийн**, “Чандмань Баянхонгор” ХК зэрэг байгууллагуудын үйл ажиллагаатай газар дээр очиж танилцлаа.

## АРАВ.ИДЭВХ САНААЧИЛГА, ШИНЭЛЭГ АЖЛЫН ТАЛААР

Хэлтсээс ажилтнуудын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд өөрсдийн мэдлэг ур чадвараа дээшлүүлэх ажил буюу илтгэл мэдээлэл хийх, сэдэв сонгон хичээл заах, шинэлэг ажил санаачлан хэрэгжүүлэх зэрэг шаардлагуудыг тавьж батласнаар дараах ажлууд зохион байгуулагдлаа.

Тус хэлтсээс Үндсэн хуулийн өдрийг тохиолдуулан "Үндсэн хуулийг



хэн сайн мэдэх вэ" АХА тэмцээнийг удирдамжийн дагуу зохион байгуулж эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч Т.Мягмарсүрэн түрүүлж, удаах байруудад хяналтын улсын байцаагч Л.Мэндбаяр, хуулийн этгээдийн улсын бүртгэгч Д.Отгонсүрэн нар шалгарлаа.

"Хөдөлмөрийн аюулгүй байдал ,эрүүл ахуй" сарын аяны хүрээнд хэлтсийн хамт олон ажлын байрны аюулгүй байдал болон үйлчлүүлэгчдийн тав духтай



орчныг бүрдүүлж өөрсдийн нөөц бололцоондоо тулгуурлан үйлчилгээний заалны текийг ширээ болгон өөрчиллөө.

Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар зохион байгуулж буй "Эрүүл монгол хүн" үндэсний хөдөлгөөн, "Энэ жилдээ -эрүүл жиндээ","Цаг гаргая" аянд нэгдэж сургалт мэдээлэл авснаар хэлтсийн хамт олон 5 сарын 12-ны өдөр 08.00 цагт ажлын байрандаа мэргэжлийн багшаар спорт бүжиг заалгаж эрүүл мэнддээ хөрөнгө оруулалт хийсэн ба дараагийн сургалт 11 дүгээр сарын 27-ны өдөр эхлэхээр гэрээ хийгдсэн болно.



Улсын бүртгэлийн хэлтэст Төрийн банкны "Пос" болон Гэрэгэ пос машинуудыг Нэг цонхны үйлчилгээ, Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газарт байрлан ажилладаг улсын бүртгэгч, хэлтсийн бүртгэгч нарт тус тус ажиллуулж иргэдэд чирэгдэлгүй үйлчилж байна.

Цахим бүртгэлийг хөгжүүлэх замаар улсын бүртгэлийн үйлчилгээний чанар, хүртээмж, шуурхай байдлыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд хэрэгжүүлж байгаа олон ажлын нэг болох "Барьцааны гэрээний болон барьцааны гэрээ дуусгавар болох бүртгэлийг цахимаар бүртгэх системийг нэвтрүүлж буй талаарх танилцуулга", "Барьцааны гэрээ /ипотек/-г эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэх /ЭУБ-06/ хүсэлтийн асуулгыг нэг мөр ойлгож алдаагүй үнэн зөв бөглөж ирүүлэх, Барьцааны гэрээг бүртгүүлэхэд анхаарах зүйл", "Тоон нарын үсэг, түүнийг хэрэглээнд нэвтрүүлэх" сэдэвт семинарыг 4



сарын 28-ны өдөр зохион байгууллаа. Энэ удаагийн сургалтанд Баянхонгор аймагт үйл ажиллагаа эрхэлдэг Номгон финанс, Капмон, Транскапитал, Нэт капитал финанс, Бэрс финанс, Сэндли, Номгонбуурал, Гялстөгрөг зэрэг банк бус санхүүгийн байгууллагуудын зээлийн эдийн засагч нар хамрагдлаа.

Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас ирүүлсэн уриалгын дагуу "Сайн үйлсийн өдөр" аянд нэгдэж тус хэлтсийн хамт олон 2023 оны 04 дүгээр сарын 22-ны Бямба гарагт Аймгийн ГХУСАЗ салбар зөвлөлөөс зохион байгуулсан "Хүн бүр байгаль хамгаалагч" уриатай "БАЙГАЛИА ХАМГААЛЪЯ" нэгдсэн арга хэмжээнд оролцож Самбартай хөтөл орчмыг хог цэвэрлэгээг оролцогч байгууллагатай хамтран хийж гүйцэтгэлээ.



Төрийн байгууллагаас тэр дундаа Улсын бүртгэлийн байгууллагаас үзүүлэх үйлчилгээг хэрхэн хүнд сурталгүй иргэдэд түргэн шуурхай хүргэдгийг өөрийн ажил хөдөлмөрөөрөө түүх болгон үлдээж, үргэлж хичээнгүй хариуцлагатай ажиллаж буй хувь нэмрийг нь үнэлүүлэхээр тодорхойлсон улсын бүртгэгч



Г.Бадамханд "Усан Туулай" жилийн босгон дээр "Аймгийн Хөдөлмөрийн аварга"-аар шалгарлаа.

Баянхонгор аймгийн Засаг дарга Д.Мөнхсайхан, Баянхонгор сумын Засаг дарга Г.Энхбаяр, ГХБХБГ-ын Газрын удирдлагын хэлтсийн дарга А.Цэцэнбилэг



нар Баянхонгор сумын Шаргалжуут наймдугаар багт /2023.05.10/ ажиллаж иргэд хөдөлмөрчидтэй уулзалт хийв. Энэ үеэр Улсын бүртгэлийн хэлтсийн явуулын баг 5 сарын 10-аас 11-ний өдрүүдэд ажиллаж тус багийн иргэд болон Шаргалжуут рашаан сувилалд амрагчдад Тоон гарын үсгийн талаар мэдээлэл хийж бүртгэл хөтөллөө. Улсын бүртгэгч Г.Бадамханд 146, Б.Өлзийбаяр 411 бүртгэл хөтөлсөн байна.

### **ДҮГНЭЛТ, САНАЛ**

Улсын бүртгэлийн хэлтэс нь УБЕГ-аас өгсөн зөвлөмж, чиглэлийг баримтлан хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд Хэлтсийн албан хаагч, сумдын улсын бүртгэгч нараар дамжуулан бүрэн эрхээ хэрэгжүүлж, 2023 оны үндсэн зорилтоо амжилттай хэрэгжүүлэн ажиллалаа. Дараах саналыг хүргүүлж байна.

#### **Бүртгэлийн хэвийн үйл ажиллагааг хангах талаар**

**1.1** Бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай чирэгдэлгүй хүргэхэд шаардлагатай тоног төхөөрөмж шинэчлэлт хийгдсэн боловч сүлжээний доголдол тасалдал байнга үүсэж байгаа тул найдвартай байдлыг хангах арга хэмжээг авах

**1.2** Улсын бүртгэлийн зөөврийн төхөөрөмжөөр дахин 1-ийг нэмж хангах арга хэмжээг авах. **Учир нь**, нэгдсэн төвлөрсөн арга хэмжээнд оролцож улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх, зорилтод бүлгийн хөгжлийн бэрхшээлтэй, хэвтрийн дэглэмтэй болон урьдчилан хориход хоригдож байгаа иргэдэд улсын бүртгэлийн явуулын үйлчилгээг үзүүлэхэд нэн тохиромжтой байдаг.

**1.3** Бүртгэлийн архивын баримтын хадгалалт хамгаалалтыг сайжруулахад анхаарч орон нутгийн хэлтсүүдэд байгууллагын болон төрөлжсөн архивын хадгаламжийн нэгжийн хамгаалалтын хайрцаг /A4/ бэлтгэн нийлүүлэх.

**1.4** Байгууллагын архивыг нягтруулсан шүүгээгээр хангах

## **2. Албан хаагчдын ур чадварыг нэмэгдүүлэх, мэргэшсэн тогтвортой байлгах талаар**

2.1 Хөдөлмөрийн дотоод журманд заасан тусламж дэмжлэгийг тогтоосон хэмжээгээр олгоход шаардагдах төсвийг бүрэн тусган батлуулж олгох ;

2.2 УБЕГ-аас дүүрэг, аймгуудын хэлтсүүдийн ажилтнуудын туршлага солилцох сургалт семинарыг бүсчилж зохион байгуулах

Эдгээр саналыг анхааран шийдвэрлэх нь байгууллага, албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг сайжруулах, бүртгэлийн байгууллагын хэвийн ажиллах нөхцөл боломжийг бий болгоход ач холбогдолтой байх болно.

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.МӨНХЖАРГАЛ